Англи хэлнээс орчуулав.

КАЙМАНЫ АРЛУУДЫН ДЭЭД ШҮҮХ САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

Шүүх шалтгааны (хэргийн) дугаар: FSD 127/2019

КОМПАНИЙН ТУХАЙ ХУУЛИЙН АСУУДАЛ (2018 ОНЫ ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА) БОЛОН ЛАНГ МИНГ МАЙНИНГ ХЯЗГААРЛАГДМАЛ КОМПАНИЙН АСУУДЛЫН ТУХАЙ

Оролцсон:

Ноён Спенсер Викерс Коньерс Дилл & Пирман Албан ёсны Хамтарсан Татан буулгагчдыг төлөөлж буй

Ноён Ли Сиао Минг-ийг төлөөлж буй Хиггс & Жонсоны ноён Жон Харрисын зааварчилгааны дагуу ноён Том Лоу

Коньерс Дилл & Пирман-ийн ноён Бен Хобден Өргөдөл гаргагч Зээлдүүлэгчдийг төлөөлж буй

CIC Зээлдүүлэгчийг төлөөлж Харнисийн хатагтай Жессика Уильямс

Өмнө нь: Эрхэм шүүгч Шерил Ричардс Q.C
Сонссон: 2020 оны 5-р сарын 20
Шийдвэр: 2020 оны 5-рсарын 27

ТЭМДЭГЛЭЛ

Компанийн тухай хууль (2018 оны шинэчилсэн найруулга) - 152-р Хэсэг - *Компанид үлдэгдэлтэй хөрөнгө байгаа эсэх, Компанийн үйл ажиллагаа бүрэн татан буугдсан эсэх, ХТБ-ын улмаас хангалттай хохирол учирсан эсэх*

ШИЙДВЭР

1. 2019 оны 11-р сарын 18-ны өдөр гаргасан Зарлан дуудлагаар Ланг Минг Майнинг Хязгаарлагдмал Компани ("Компани")-ийн Хамтарсан Албан ёсны Татан буулгагчид ("ХТБ" гэх) болох ноён Патрик Коулей болон Крис Бейтон нар нь ***Компанийн тухай хуулийн*** (2018 оны шинэчилсэн найруулга) 152(1)-р хэсэг болон Компанийг Татан Буулгах Журмын 2018 оны 22 тоот Тушаал ("CWR") дагуу татан буулгах хүсэлт гаргасан.

2. Компанийн үйл ажиллагаа бүрэн татан буугдсан гэх үндэслэлээр гаргасан өргөдлийг ноён Ли Сиао Минг ("Ноён Ли" гэх) эсэргүүцсэн байна. Ноён Ли нь хяналтын эрх бүхий хувьцаа эзэмшигч байсан бөгөөд тус Компанийн өмнө нь захиралаар ажиллаж юм. Компани нь чухал үнэ цэнэ бүхий хөрөнгийн өмчлөгч нь бөгөөд ХТБ энэ хөрөнгийг зохих ёсоор шалгаагүй, анхаарч авч үзээгүй гэж түүний өмнөөс дүгнэлтэд нотлогдсон байна. 2020 оны 5-р сарын 20-ны өдөр хоёр тал бичгээр гаргасан маргаанд нэмэлтээр амаар өргөн хэмжээний маргаан, мэтгэлцээн хийсэн. 2020 оны 5 дугаар сарын 27-ны өдөр миний бие шийдвэрээ гаргасан ба ингэхдээ бүрдүүлсэн нотлох баримт, гаргасан мэдүүлэг, татан буулгах тухай хүсэлтийг хангаж шийдвэрлэсэнийг хянаж үзсэн. Миний бие үндэслэл шалтгаанаа бичгээр өгөх тухай хүлээсэн үүргээ ийнхүү биелүүлж байна.

3. ХТБ-ууд өргөдөл гаргахдаа тухайн асуудлын явцын түүхэнд ихээхэн үндэслэсэн байх тул өргөдөл гаргахаас өмнөх суурь нөхцөл, үйл явдлуудыг тодорхой зааж өгөхийг санал болгож байна.

4. Компани нь 2018 оны 5-р сарын 6-нд Кайманы Арлуудад хариуцлагаас чөлөөлөгдсөн хязгаарлагдмал хариуцлагатай компани хэлбэрээр байгуулагдсан. Ингэхдээ Монгол болон БНХАУ-д үндсэн бизнесийн үйл ажиллагаа явуулдаг холдинг компанийн үүрэг гүйцэтгэж байсан. Эдгээр үйл ажиллагаанд төмрийн хүдэр олборлох үйлдвэрлэх, Монголын Ерөө Голын Төмрийн хүдрийн уурхайнуудын үйл ажиллагаа зэрэг ордог байсан.

5. 2019 оны 7-р сарын 3-ны өдөр Компанийн зээлдүүлэгч Хятадын Хөгжлийн Банк (China Development Bank буюу "CDB" гэх) Компанийг Татан буулгах тухай Өргөдөл гаргаж, Албан ёсны Татан Буулгагчдыг томилохыг хүссэн байна. Өргөдөл гаргах үндэслэл нь Компанийг төлбөрийн чадваргүй, өр төлбөрөө төлөх боломжгүй болсон гэж үзжээ. Өргөдлийг 2019 оны 8-р сарын

ПЕРЕВОДЧЕСКОЕ БЮРО TRANSLATION BUREAU

16-ны өдөр сонсгож, хянан хэлэлцсэн. Сонсгол шүүх хурал болох өдөр оройтож гаргасан өргөдөлдөө ноён Ли-гийн өмнөөс төлөөлөх Өмгөөлөгч нь өрийг хүлээн зөвшөөрөхийн зэрэгцээ, өргөдлийг няцаан эсэргүүцэж, шүүх хурлыг хойшлуулах эсвэл түр татан буулгагчдыг томилохыг хүссэн. Шүүхээс хойшлуулах, албан ёсны бус түр татан буулгагчийг томилох үндэслэл болох зэрэг шалтгаант үндэслэл, нотлох баримт ирүүлээгүй гэж үзэв. Зээлдүүлэгчийн хүсэлтийг хангаж, Компанийн ХТБ-ыг томилох Тушаал гаргасан.

6. Томилогдсоныхоо дараа ХТБ нь CDB-ээс гадна Компанийн өөр хоёр зээлдүүлэгчийг тодруулсан ба бүгд БНХАУ-ын банкууд байх аж. Тус компанийн нийт өр ойролцоогоор 2.21 тэрбум ам.доллар байна. ХТБ-ын анхны тайланг 2019 оны 9-р сарын 19-нд шүүхэд ирүүлсэн.

7. 2019 оны 11-р сарын Зарлан дуудах хүсэлтийг ноён Коулейгийн 2019 оны 11-р сарын 27-ны өдрийн Хоёр дахь мэдүүлгээр дэмжсэн. Тараах, татан буулгах сонсгол шүүх хурлыг 2019 оны 12-р сарын 17-нд хийхээр товлосон. Шүүх хурлын товыг 2019 оны 11-р сарын 29-ний өдөр Кайманы арлуудын сэтгүүлд, хэвлэлд, 2019 оны 12-р сарын 2-ны өдөр Монгол, БНХАУ-д тус тус зарласан. 2019 оны 12-р сарын 4-нд ХТБ нар Эцсийн Тайлангаа шүүхэд хүргүүлэв.

КОМПАНИЙН САНХҮҮГИЙН БАЙДАЛ

8. ХТБ-ын эцсийн тайланд ноён Ли тухайн үе хүртэл компанийн үйл ажиллагааны тайлан мэдээлэл, дэвтэр, бүртгэлийг гаргаж өгөөгүй тухай тэмдэглэсэн байдаг. Тиймээс ХТБ гуравдагч этгээд болон оролцогч талуудаас авсан мэдээлэлд тулгуурласан. Банкны бүртгэлийг шалгахад Компанийн хоёр банкны дансны үлдэгдэл 0 байсан. Бэлэн мөнгөний мөшгих туршилт шалгалт хийгдсэн бөгөөд үндсэн мөнгө шилжүүлсэн баримт байхгүй. ХТБ-чид 2019 оны 10-р сарын 8-нд ноён Ли-тэй уулзсан. Тэд түүнтэй 2015 онд Компанид хийгдсэн бүтцийн өөрчлөлтийн талаар ярилцсан. Тэрээр тэдэнд одоогийн байдлаар Компанийн[1] эзэмшилд байгаа томоохон хөрөнгө байхгүй, Компанийн охин компаниуд эзэмшиж байсан бодитой хөрөнгө байхгүй гэдгийг баталгаажуулсан. Эдгээр мэдэгдлийн баттай байдалд үндэслэн, мөн энэхүү мэдэгдлийн үнэн зөв эсэхэд эргэлзээ төрүүлэх өөр материал олдоогүй тул ХТБ-чид охин компаниудын хяналтыг авахын тулд

[1] Эцсийн Тайлан 2019 оны 12 дугаар сарын 3, 1 дэх хэсэг, 3х

цаашид авах арга хэмжээг зөвтгөх боломжгүй гэж мэдэгдсэн. Тайланд "*Бүх охин компаниудын хувьцааг үнэ цэнэгүйд тооцож, Компанийг тараах татан буулгахаас өмнө орхих болно*"[2] гэж тусгажээ.

9. Ноён Коулейгийн[3] 2019 оны 11-р сарын 25-ны өдрийн Хоёр дахь Мэдүүлэгт дурдсанчлан ХТБ нь Компанийг Компанийн зээлдүүлэгчдийн ашиг тусын тулд худалдан авах боломжтой бодит тодорхойлогдох хөрөнгөгүй гэж дүгнэсэн. Үүнээс гадна, тэд татан буулгахтай холбоотой бүх ач холбогдол бүхий чухал асуудлуудыг шийдвэрлэсэн бөгөөд компанийг татан буулгах ажлыг аль болох хурдан эхлүүлэх нь зүйтэй гэж үзсэн. Санхүүжилтийн асуудлын хувьд ноён Коулей хэлэхдээ[4]:

> *"Үүнээс гадна, компанийн зээлдүүлэгчид ХТБ-д Компанийн асуудлаар нэмэлт мөрдөн байцаалт явуулах боломжийг олгохын тулд ямар нэгэн санхүүжилт олгох хүсэлгүй байгаагаа илэрхийлсэн."*

МАРГААН БҮХИЙ ХӨРӨНГӨ

10. 2019 оны 12-р сарын 17-ны өдөр тараах, татан буулгах тухай анхны сонсгол шүүх хурал болохоос нэг өдрийн өмнө ноён Лигийн нэрийн өмнөөс түүнийг төлөөлж буй өмгөөлөгчид 2019 оны 12-р сарын 4-ний өдөр шилжүүлгийн баримт үйлдсэн байх буюу өөр компанийн Хувьцаа: Шайни Глоу Лимитед (Shiny Glow Limited буюу "SGL" гэх) компанийн хувьцааг Компанид шилжүүлсэн тухай ХБТ-д мэдэгдсэн. SGL нь Их Британийн Виржинийн арлуудад бүртгэлтэй. Сонсгол шүүх хурал болох өдөр ноён Ли, ноён Ван Юан Хэнг нар 2019 оны 12-р сарын 17-ны өдөр нотлох баримтуудыг гаргаж өгсөн. Ноён Ван нь Компанийн зөвлөхөөр ажиллаж байсан.

11. Эдгээр мэдэгдлүүдийн дагуу ноён Ли дүгнэхдээ: SGL-ийн эзэмшиж байсан гуравдагч компани болох Пийс Фейм Лимитед (Peace Fame Limited буюу "PFL" гэх) компанийн гаргасан бүх хувьцааг одоо Компанид 1.00 Хонгконг долларын нэрлэсэн төлбөрийн хувиар шилжүүлсэн гэж мэдэгдэв. Үүний дараа, PFL-ийн охин компани болох Эрээн хотын Ланг Минг Төмөр Замын Үйлчилгээн ба Хөгжлийн Компани (Erlian Lung Ming Railway Services and Development Company Ltd буюу "Эрээн" гэх)-ийн эзэмшиж байсан үнэт хөрөнгийг Компанид шилжүүлсэн гэх нэхэмжлэлийн шаардлага байв.

[2] Эцсийн Тайлан 2019 оны 12 дугаар сарын 3, 2 дэх хэсэг, 4х
[3] Патрик Коулейгийн Хоёр дахь удаагийн Мэдэгдэл 2019 оны 11 дүгээр сарын 25, 17 дахь хэсэг
[4] Патрик Коулейгийн Хоёр дахь удаагийн Мэдэгдэл 2019 оны 11 дүгээр сарын 25, 18 дахь хэсэг

PFL-ийг аудитын тайланд үндсэн үйл ажиллагаа нь хөрөнгө оруулалтын холдинг бүхий хувийн хязгаарлагдмал компани гэж тодорхойлсон байна. 2011 оны 2-р сарын 7-нд Хонг Конгд байгуулагдсан бөгөөд Эрээн-ий 100 хувь эзэмшигч гэгддэг аж. Эрээн нь БНХАУ-ын Эрээн хотод үл хөдлөх хөрөнгө эзэмшдэг ба эдгээрт Монгол, Хятадыг холбосон төмөр замын дэд бүтцийг багтдаг байна ("Хөрөнгө" гэх).

12. 2019 оны 12-р сарын 17-ны өдрийн анхны мэдэгдлээр ноён Ли нь дараах бүрдлээс бүрдсэн баримт бичгийн багцыг бэлтгэсэн байна;
    i. 2019 оны 12-р сарын 4-ний өдрийн SGL-ийн цорын ганц захирлын тогтоолууд.
    ii. 2019 оны 12 дугаар сарын 4-ний өдөр хуралдсан SGL-ийн ээлжит бус ерөнхий хуралдааны ("EGM" гэх) тэмдэглэл.
    iii. PFL-ийн Гишүүдийн бүртгэл.
    iv. Компанийн Группын бүтцийн диаграм.

13. Ноён Лигийн гарт байсан захирлын бичгээр гаргасан тогтоолд:
    "Компанийн эзэмшиж буй Пийс Феймм Лимитед-ийн бүх хувьцааг 1.00 Хонгконг долларын нэрлэсэн үнээр (Шайни Глоу Лимитед) *Ланг Мингд шилжүүлэхээр шийдсэн ба нэн даруй хүчин төгөлдөр болно"* гэж хэсэгчлэн дурджээ. SGL болон Компанийн хувьцааны бүртгэлийг тухайн өдөр SGL-ээс Компанид шилжүүлсэн болохыг харуулсан.

14. Ноён Ли Хоёр дахь Мэдэгдэлдээ[5]:
    "Дээрх тогтоолуудын үр нөлөө нь Хятадын охин компанийн (Эрээн Ланг Минг Төмөр замын үйлчилгээ, Хөгжлийн ХХК) зохих ёсны эзэмшилд байсан үнэ цэнэтэй үл хөдлөх хөрөнгийг Компанийн өмчлөлд буцааж шилжүүлэх явдал юм. 2015 онд бүтцийн өөрчлөлт хийх үед энэ хөрөнгийн үнэлгээ нь 506.38 сая юань байсан бол сүүлийн үеийн үнэлгээ нь 952,940.213.17 юань байна."[6]

15. Тухайн үед шинээр ирүүлсэн мэдээллийг харгалзан ХТБ-чид асуулга явуулах цаг гаргах зорилгоор тараах, татан буулгах сонсгол шүүх хурлыг хойшлуулах хүсэлт гаргасан. Тэдгээрийн хүсэлтээр шүүх хурлыг 2020 оны 1-р сарын 29-нд хийхээр товлов. Энэ хооронд нэг талаас ХТБ, нөгөө талаас ноён Ли, ноён Ванг нарын хооронд олон олон санал солилцсон.

[5] 2019 оны 12 дугаар сарын 17
[6] 4 дүгээр хэсэг

ҮЙЛ ЯВДЛЫН ОН ЦАГИЙН ДАРААЛАЛ БА ХУВЬЦАА ШИЛЖҮҮЛЭГ

16. ХТБ-ын нэрийн өмнөөс түүнийг төлөөлж өмгөөлөгч дараах зүйлсийг багтаасан үйл явдлын нарийвчилсан цагийн хуваарийг гаргаж өгсөн байна.

2019 оны 8-р сарын 16	ХТБ-чдын томилгоо
2019 оны 10-р сарын 8	Ноён Ли болон ХТБ нарын уулзалт
2019 оны 11-р сарын 4	SGL-ийн ээлжит бус ерөнхий хурлыг (EGM) зарлах тухай мэдээлэл
2019 оны 11-р сарын 15	Ноён Лигийн эсрэг Хонгконгийн шүүх дампуурлын Тогтоол гаргасан огноо (давж заалдах дээр)
2019 оны 11-р сарын 25	SGL-ийн EGM-ийн шинэчилсэн мэдэгдэл
2019 оны 12-р сарын 4	SGL-ийн EGM, PFL-ийн бүх хувьцааг 1.00 Хонгконг долларoop төлөхөөр Компанид шилжүүлэх шийдвэр.
2019 оны 12-р сарын 16	ХТБ-чид шилжүүлэхийг зөвлөж байна
2019 оны 12-р сарын 17	Тараах, татан буулгах тухай анхны сонсгол хэлэлцүүлгийн өдөр
2019 оны 12 сарын 31	Эрээн-ийг 134 сая ам.доллараар хязгаарласан үнэлгээгээр үнэлсэн Анхын Үнэлгээ
2020 оны 1-р сарын 29	Тараах, татан буулгах тухай хоёр дахь сонсгол хэлэлцүүлгийн өдөр

ТАРААХ,ТАТАН БУУЛГАХ ТУХАЙ ХОЁР ДАХЬ СОНСГОЛ ШҮҮХ ХУРАЛ 2020 ОНЫ 1-Р САРЫН 29

17. Тараах, татан буулгах тухай сонсгол шүүх хуралдааны хоёр дахь өдрөөр ХТБ-ыг төлөөлж буй өмгөөлөгч шаардлагатай лавлагаагаа авсан ба татан буулгах тухай тушаал гаргах нь зүйтэй гэж мэдэгдэв. Үүнийгээ дэмжих үүднээс нотлох баримтыг ноён Коулейгийн 2020 оны 1-р сарын 29-ний өдрийн гурав дахь мэдүүлэг хэлбэрээр гаргаж өгсөн. Дүгнэж хэлэхэд, ХТБ дараахь зүйлийг баталжээ.

i. PFL-ийн хувьцаа болон PFL-ийн хөрөнгө нь бусад зээлдүүлэгчдээс авах хураамж ба/эсвэл гэрээний хязгаарлалтын субъект байж болох ба Хятадад шүүхэд гаргах нэхэмжлэлийн субъект байх боломжтой.

ii. SGL-ийн хөрөнгө нь шилжүүлгийн хязгаарлалтад өртөж, зээлдүүлэгчийн нэхэмжлэлээр хязгаарлагдсан бололтой.

iii. Өмнө нь 200 сая ам.доллараар үнэлэгдэж байсан хөрөнгийг нэрлэсэн үнээр нь шилжүүлэх баттай арилжааны шалтгаан байхгүй.

iv. Дараахь тохиолдолд шилжүүлгийн хүчинтэй эсэхэд ихээхэн эргэлзээ гарч байсан.

a) 2019 оны 11-р сарын 15-нд ноён Лигийн эсрэг Хонгконгийн дампуурлын тогтоол гарсан байх бөгөөд тэрээр SGL-ийн захирлын хувиар ажиллаж чадах эсэх нь тодорхойгүй байсан.

b) Тооцоолсон шилжүүлэг нь маш доогуур үнэлэгдсэн.

c) Компани нь ХТБ-ын талаар мэдээлэлгүйгээр, Компани ийм хөрөнгийн төлбөр төлөхгүйгээр албан ёсоор татан буугдаж байх үедээ хөрөнгөтэй болсон.

d) Ноён Ли нь 2019 оны 12-р сарын 4-ний өдөр ХТБ томилогдсоны дараа, мөн Компанийг төлөөлөн ийм баримт бичигт гарын үсэг зурах эрхгүй байтал Компанийн нэрийн өмнөөс шилжүүлгийн баримт бичгийг гүйцэтгэнэ гэж мэдэгдсэн.

e) Ноён Лигийн өгсөн PFL-ийн үндсэн хөрөнгийн үнэлгээ нь PFL эсвэл SGL-ийн одоо байгаа өр төлбөрийг тооцоогүй болно.

18. ХТБ-чид шилжүүлсэн гэх цорын ганц зорилго нь Компанийг татан буулгах хугацааг хойшлуулах явдал гэж үзэж байна. Ноён Ли-д тэдэнтэй асуудлыг хэлэлцэж, бүтцийн өөрчлөлтийн хэлэлцүүлэгт орох хангалттай боломж байсан ч тэрээр нууцаар шилжүүлэг хийхийг оролдсонд тэд санаа зовж буйгаа илэрхийлэв. Тэд Компанид хөрөнгө шилжүүлсэн гэж байгаа нь хуульд заагаагүй учраас зээлдүүлэгчдэд ашиггүй, эд хөрөнгийн шилжүүлэг нь хязгаарлалтын, зээлдүүлэгчийн нэхэмжлэлийн шаардлагын субъект болсон гэж дүгнэсэн.

19. Ноён Ли татан буулгахыг дахин эсэргүүцэж, түүний өмнөөс төлөөлж буй өмгөөлөгч нь ХТБ нар нь маргаантай эд хөрөнгөтэй холбоотой зохих шалгалт байцаалтыг хийгээгүй гэж маргасан. Ноён Ли 2020 оны 1-р сарын 23-ны өдрийн Гурав дахь Мэдэгдэлдээ Компани болон тухайн үеийн зээлдүүлэгчдийн нэг болох CDB зэрэг бусад байгууллагуудын хооронд 2015 оны Төлбөрийн Гэрээний 2.8(b) заалтад заасны дагуу хувьцааг шилжүүлсэн гэж мэдэгдэв. Энэ Гэрээг Компанийн хийсэн амжилтгүй бүтцийн өөрчлөлтийн нэг хэсэг болгон байгуулсан. Тэрээр 2015 оны 10 дугаар сарын дотор CDB-ний төлбөрийг төлөөгүй тохиолдолд PFL-ийг SGL-д шилжүүлгийг өөрчилж, хувьцааны эзэмшлийг Компанид буцааж өгөх нь Гэрээний нэг нөхцөл байсан гэж мэдэгдэв.[7]

20. CDB-ний төлбөрийг төлөөгүй талаар маргаагүй.

[7] Ли Сиао Мингийн Гурав дахь удаагийн Баталгаажуулах Мэдэгдэл 2020 оны 1 дүгээр сарын 23, 8 дахь хэсэг

ИСПЕРА ХХК
TRANSLATION BUREAU
AMC00416 5616595
УЛААНБААТАР ХОТ

21. Ноён Ли цааш нь үргэлжлүүлж, Эрээний үл хөдлөх хөрөнгийн үнэлгээг хийлгэхээр ХТБ нарт айлчлах урилга хүргүүлсэн бөгөөд тэрээр Хөрөнгийн үнэлгээнд дэмжлэг үзүүлэх зорилгоор аудитын тайлан, удирдлагын данс, үнэлгээ зэрэг олон баримтыг өгсөн гэж мэдэгдэв. Тэрээр ХТБнар Хөрөнгийн бодит үнэ цэнийг өөрийн биеэр шалгахын тулд ямар ч хүчин чармайлт гаргаагүй, түүний үнэ цэнийг тэг, нооль гэж таамаглаж байна гэж тайлбар тавив. Тэрээр ХТБ-дыг Хөрөнгийг Компанид буцаан өгөхөд саад учруулж, уг Хөрөнгийг зөвхөн нэг зээлдүүлэгч болох CDB-д ашиглах боломжтой байлгахыг оролдсон, мөн Компанийн бүх зээлдүүлэгчдийн ашиг сонирхолд нийцүүлэн ажиллах үүрэг хариуцлагатай зөрчилдсөн үйлдэл гаргасан гэж буруутгав. ХонгКонгийн Хуулийн дагуу, тэр дундаа хувьцааг нэрлэсэн үнээр шилжүүлж байгаатохиолдолд шилжүүлгийн баримт бичгийг шилжүүлэгч этгээд гүйцэтгэх нь тийм ч чухал биш гэдгийг түүнд зөвлөсөн талаар тэр ХТБ-ийн гаргасан шилжүүлгийн хүчинтэй эсэх асуудалд өгсөн хариулт мэдэгдэлдээ тусгасан болно. Цаашилбал, шилжүүлгийг соёрхон батлах боломжтой эсэхийг авч үзэх нь ХТБ-дад нээлттэй байсан.

22. 2020 оны 1-р сарын 24-ний өдрийн Дөрөв дэх Мэдэгдлээрээ ноён Ли хувьцааны эргэлтийн талаар нэмэлт мэдээлэл өгсөн бөгөөд энэ нь Хөрөнгийг Компанид буцааж шилжүүлсэн гэсэн үг юм. Тэрээр 2016 оны 1 дүгээр сарын 5-ны өдрийн 2015 оны Гэрээний 2.8(b) заалтад оруулсан Нэмэлт, өөрчлөлтийн хуулбарыг нотлох баримт болгон гаргаж өгсөн. Мөн зээлдүүлэгчид, 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн CDB, 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн Эксим банкнаас авсан захидал харилцааны хуулбарыг гаргаж өгсөн бөгөөд Компанид Хөрөнгийг нөхөн сэргээх замаар Гэрээг хэрэгжүүлэх хүсэлтийг нотлох баримтаар хангаж буй гэжээ. Захидлын аль нь ч PFL эсвэл Эрээнийг хэлээгүй байдаг. Түүний гаргасан CDB-ийн захидал нь PFL-д хамаарахгүй бөгөөд хэсэгчлэн дараахь нэр томъёонд багтсан болно.

> *"2016 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн "Төлбөрийн Гэрээ"-ний дагуу Ланг Минг Майнинг Төслийн үндсэн зээл болон хүүгийн эргэн төлөлтийн эх үүсвэрийг хүлээн аваагүй, 2016 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар тус Банкинд Айрон Майнинг Интернэшнл болон Шайни Глоу компанийн хувьцааны эргэлттэй холбогдох баримт бичиг ирээгүй. Тиймээс "Айрон Майнинг Интернэшнл", "Шайни Глоу", "Ланг Минг Майнинг" нар нь хамтран зээлдэгч болсон тул тус банкнаас эдгээр*

талуудад мэдэгдэх албан бичгийг хүргүүлж байна"[8]

Эксим банк нь Ланг Мингийн анхны өмчийн бүтцийг сэргээж, 2015 оны өөрчлөн зохион байгуулалтын явцад шилжүүлсэн өмч хөрөнгийг сэргээхийн тулд хувьцааны эргэлтийн гүйцэтгэлийг эрэлхийлсэн.[9]

23. Ноён Крис Бейтоны 2020 оны 1-р сарын 30-нд гаргасан Хоёр дахь Мэдэгдлийн дагуу ХТБ хариуд нь Компанийн ашиг сонирхолд нийцүүлэн ажиллаагүй, SGL шилжүүлгийг зохих ёсоор авч үзээгүй гэснийг үгүйсгэв. Тэд ноён Лигийн өгсөн баримт бичиг нь шилжүүлгийн хүчинтэй эсэх болон SGL болон түүний охин компаниудын хувьд зээлдүүлэгчийн хязгаарлалтын талаархи асуудлуудыг авч үзвэл, ХТБ-ийн санал бодлыг өөрчлөөгүй хэмээж байр суурыа илэрхийлэв.

24. Ноён Бейтон мөн 2020 оны 1-р сарын 28-нд ноён Ли 8 сая орчим ам.доллартай тэнцэх хэмжээний өрийн нотлох маягт гарган өгсөн ба өөрийгөө тус компанийн зээлдүүлэгч гэж мэдүүлжээ. ХТБ тухайн өдөр хариу өгч, ноён Лигийн 2020 оны 1-р сарын 3-ны өдрийн байдлаар сүүлд өргөсөн Хэргийн мэдэгдэлд нэхэмжлэлийн хугацаа өнгөрсөн болон нэхэмжлэлийн шаардлага байхгүй байгаа талаар нэмэлт мэдээлэл эрэлхийлсэн. ХТБ-ын мэдэгдсэнээр, тэдний олж мэдсэн мэдээллээр ноён Ли нь үнэн хэрэгтээ Компанийн зээлдүүлэгч биш байх магадлалтай гэж үзсэн байна.

25. Татан буулгах хоёр дахь сонсгол шүүх хурал Зөвшилцөх захирамж гаргаснаар өндөрлөв. Энэхүү захирамжаар татан буулгах сонсгол шүүх хуралдааныг дахин хойшлуулж, ХТБ-дад шаардлагатай лавлагаа гаргах, ноён Ли-д иш татсан шилжүүлэг, хөрөнгөтэй холбоотой баримт бичиг, мэдээллийг ХТБ-д гарган өгөх дахин нэг боломжийг тус тус олгожээ. Ноён Ли-ийн зөвлөхөөс ноён Ли энэхүү цаашдын шалгалт, лавлагааг явуулахад шаардагдах ХТБ-ын зардлыг хариуцахад бэлэн байх эсэх талаар зааварчилгаа өгсөнөөр үүнийг санхүүжүүлэх асуудлыг шийдсэн.

26. 2020 оны 1-р сарын 29-ний өдрийн Тогтоолын дагуу ХТБ нар эд хөрөнгийг SGL-ээс Компанид шилжүүлсэн гэх баримт бичиг, мэдээллийн хүсэлтийг ноён Ли-д гаргаж, түүнийг 14 хоногийн дотор хариуг нь өгөхийг шаардсан. Энэ хугацааг ХТБ нар сунгаж, 2020 оны 3-р сард хүлээгдэж буй сонсголын товыг

[8] Баримт XL – 4, 9х
[9] Баримт XL – 4, 12х

2020 оны 5-р сар хүртэл хойшлуулсан. Тогтоолын 3, 4-р хэсэгт дараах байдлаар тусгав.

> *"Хэрэв ноён Ли болон ХТБ нар Шайни Глоу-аас Компанид шилжүүлсэн гэх эд хөрөнгийн талаар ХТБ-ийн цаашдын мөрдөн шалгалтын талаар зөвшөөрсөн бол (**"Зөвшөөрсөн Мөрдөн шалгалтууд"**) ноён Ли зөвшөөрсөн мөрдөн шалгалтын талаар тохиролцсон мөнгийг ХТБ-ийн тооцоог хүлээн авсанаас хойш 7 хоногийн дотор нэн даруй, ямар ч тохиолдолд төлөх ёстой. Цаашилбал:*
>
> …
>
> *Хэрэв ноён Ли болон ХТБ нар Шайни Глоу-аас Компанид шилжүүлсэн гэх эд хөрөнгийн талаар цаашдын хийх мөрдөн шалгалтын талаар зөвшилцөл тохиролцоонд хүрч чадахгүй бол ба/эсвэлНоён Ли нь ХТБ-ын тооцоог хүлээн авсанаас хойш 7 хоногийн дотор аливаа тохиролцсон мөрдөн шалгалттай холбоотой ХТБ-ын төлбөрийг бүрэн төлөхгүй бол ноён Ли нь Шайни Глоу-аас Компанид шилжүүлсэн гэх эд хөрөнгийн талаар нэмэлт мөрдөн шалгалт явуулахад ХТБ нар нэмэлт зардал гаргаагүй гэсэн үндэслэлээр Компанийг татан буулгахыг эсэргүүцэхгүй.*
>
> *Ноён Ли нь ХТБ-ын жагсаалтыг хүлээн авсанаас хойш 14 хоногийн дотор хүссэн баримт бичиг, мэдээллийн хуулбарыг ХТБ-д гаргаж өгнө. Ноён Ли ийм баримт бичиг, мэдээллийг гаргаж өгөх боломжгүй байгаа бол ноён Ли яагаад ийм баримт бичиг, мэдээлэл өгөх боломжгүй болсон шалтгааныг бичгээр өгнө."*

ГУРАВ ДАХЬ ТАТАН БУУЛГАХ СОНСГОЛ ШҮҮХ ХУРАЛ
2020 ОНЫ ТАВДУГААР САРЫН 20

27. Татан буулгах тухай сонсгол шүүх хуралдааны гурав дахь жагсаалтын хувьд Шүүхэд дараах хэд хэдэн нэмэлт Баталгаажуулалтын баримт, Мэдүүлгийг хүргүүлэв.

i. 2020 оны 4-р сарын 3-ны өдрийн ноён Лигийн Тав дахь Баталгаа ба Баримт XL-5
ii. 2020 оны 5-р сарын 13-ны өдрийн Патрик Коулейгийн Дөрөв дэх Мэдүүлэг ба Баримт PC-4
iii. 2020 оны 5-р сарын 15-ны өдрийн Эрин Каруанагийн Эхний Мэдүүлэг ба Баримт ELC-1

TRANSLATION BUREAU
АМС00416 5616395
УЛААНБААТАР ХОТ

28. Энэхүү нэмэлт материалд 2020 оны 3-р сарын 3-ны өдрийн Хонгконгийн AP Appraisal Limited компанийн Хөрөнгийн үнэлгээ багтсан[10]. Үүнийг ноён Лигийн хүсэлтээр хийсэн бөгөөд тэрээр ХТБ-дад хүргүүлсэн. Энэ нь PFL болон түүний охин компанийн цэвэр хөрөнгийн үнэлгээг 106 сая ам доллар гэж тусгасан байна. Мөн шилжүүлгийн хүчинтэй байдлын талаарх дөрвөн хуулийн дүгнэлтийг БНХАУ[11], Их Британийн Виржинийн арлууд[12], Хонгконг[13], Кайманы арлуудаас[14] тус тус авсан.

ХУУЛИЙН ЗААЛТУУД- КОМПАНИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 152 (1)ДЭХ ХЭСЭГ

29. ***Компанийн тухай хуулийн*** 152(1) дэх Хэсэгт (2018 оны шинэчилсэн найруулга) :

"Компанийн ажил хэрэг бүрэн дуусаж тарсаны дараа Шүүх тухайн захирамж гарсан өдрөөс компанийг татан буулгах тухай захирамж гаргах, эсхүл Шүүх тохиромжтой гэж үзсэн өөр өдрийг тогтоосон тохиолдолд түүний дагуу компанийг татан буулгана."

30. CWR ("Компанийг Татан Буулгах Журам")-ыг 22 тоот Тушаалыг дараах нөхцлүүдэд:

(1) Компанийн үйл ажиллагаа бүрэн дууссаны дараа албан ёсны татан буулгагч нь

а) 10-р Тушаалын 3-р дүрмийн дагуу эцсийн тайлан, тайлан тооцоог нийтэлнэ

б) Компанийг татан буулгах тогтоол гаргуулахаар 152 дэх Хэсгийн дагуу Шүүхэд хүсэлт гаргана

(2) Албан ёсны татан буулгагчийн эцсийн тайлан, тайлан тооцоонд дараахь зүйлийг тусгана.

а) Татан буулгах тухай тогтоол гаргуулахаар хүсссэн өргөдлийн дагуу Шүүх хэлэлцэх товын тухай мэдэгдэл, мөн

б) Өргөдөл гаргахад аливаа зээлдүүлэгч (төлбөрийн чадваргүй компанийн хувьд) эсвэл гишүүн (төлбөрийн чадвартай компанийн хувьд) хүрэлцэн ирж, сонсох боломжтой тухай мэдэгдэл.

(3) Албан ёсны татан буулгагч нь тухайн компанийн зээлдүүлэгчид байх

[10] Баримт РС – 4, 50х
[11] Баримт РС – 4, 73-76х
[12] Баримт РС – 4, 82-86х
[13] Баримт РС – 4, 87-92х
[14] Баримт ELC – 1

ИСПЕРА ХХК
INSPERA
BUREAU
АМС00416 5616395
УЛААНБААТАР ХОТ

магадлалтай улс эсвэл улс оронд тараагддаг нэг буюу хэд хэдэн сонинд өргөдлийн сонсгол хурлын тухай мэдэгдлийг нийтлэх бөгөөд уг мэдэгдлийг сонсгол шүүх хуралдааны товлосон өдрөөс 14-өөс доошгүй хоногийн өмнө нийтэлсэн байна".

АСУУДЛУУД

i) Ажил хэрэг бүрэн дууссан эсэх

31. ХТБ-дын зүгээс PFL-ийн хувьцааг бодит байдал дээр Компанид шилжүүлээгүй, шилжүүлсэн байсан ч бодит үнэ цэнэгүй гэсэн байр суурьтай байна. ХТБ-ын хийсэн цаашдын мөрдөн шалгалтын явцад бодит үнэ цэнэтэй ямар ч хөрөнгө илрээгүй бөгөөд Татан буулгах ажиллагааг үргэлжлүүлэх нь ямар ч ашиггүй хэмээн мэдэгдэв. ХТБ-ийг төлөөлж буй өмгөөлөгч нь зээлдүүлэгчээс Компанийн эсрэг 2.2 тэрбум ам.долларын нэхэмжлэл гаргаж байгааг онцолж, татан буулгахыг эсэргүүцэж байгаа цорын ганц хүн бол ноён Ли хэмээв. Өмгөөлөгч мөн Шүүхээс ХТБ-ийг томилсоноос хойш өнгөрсөн хугацааг харгалзан үзэхийг хүссэн. Анх томилогдсоноос хойш есөн сар, татан буулгах хоёр дахь сонсгол шүүх хурлаас хойш дөрвөн сар өнгөрсөн байна.

32. Ноён Лигийн нэрийн өмнөөс түүнийг төлөөлж буй өмгөөлөгч нь Хуулийн 152-р зүйлд заасны дагуу Компанийн үйл ажиллагаа тасраагүй гэсэн хариу өгч байна. Хууль нь энэ тохиолдолд хангагдаагүй татан буулгах аливаа тушаалыг Хуульд заасан урьдчилсан нөхцлийг тогтоосон тухай Өмгөөлөгч хүргүүлсэн. Хуулийн урьдчилсан нөхцлийн хувьд Компанийн үйл хэрэг бүрэн дууссан тухай нотлох баримт байх ёстой бөгөөд эс бөгөөс Шүүх ийм шийдвэр гаргах эрхгүй болно. Энэ нь үзэмжийн асуудал бус, харин харьяалал байгаа тохиолдолд Шүүх Тогтоол, захирамж гаргах шаардлагатай. Өмгөөлөгчийн зүгээс үргэлжлүүлэн өргөдөл гаргагчдыг энэ хэрэгт хэрэгжүүлж чадаагүй шүүхийн харъяаллыг Шүүхэд нотлох үүрэгтэй гэж онцолж байна.

33. Ноён Лигийн нэрийн өмнөөс түүнийг төлөөлж буй өмгөөлөгч Англиийн давж заалдах шатны шүүхээс сайн дурын үндсэн дээр татан буугдаж буй ***In re London болон Caledonian Marine Insurance***[15] компанийн хэргийг авч үзэж, Компанийн тухай хуулийн 152-р зүйл, 142-р хэсэгтэй ижил төстэй заалтыг дурджээ. Их Британийн ***Компаниудын тухай Акт 1862*** нь:

"Компанийн үйл ажиллагаа бүрэн дуусмагц татан буулгагчид татан буулгах арга хэмжээ, компанийн эд хөрөнгийг захиран зарцуулсан зэргийг

[15] (1879) 11 Ch.D.140

харуулсан данс байгуулна."

34. Энэ хэрэг дээр тулгуурлан Өмгөөлөгч нь орон нутгийн зохицуулалт дахь ижил төстэй үгс нь компанийг татан буулгах бодит чадвартай холбоотой гэж мэдэгдэв. Энэ нь боломжгүй даалгавар биш бөгөөд татан буулгагч нарын үзэл бодол, тэд хийх ёстой зүйлээ үндэслэлтэй гэж бодож байгаа эсэхтэй ямар ч холбоогүй гэж тэр маргав. Ямар ч үе шатанд үндэслэлтэй эсэхийг шалгах ямар нэг хэлбэр эсвэл Татан буулгагчийн өөрийн үзэл бодол чухал гэсэн санал байдаггүйг хэлэв. Татан буулгагч эд хөрөнгөтэй холбоотой юу хийж чадах эсэх талаар Шүүх өөрийн үзэл хандлагыг тогтоох нь зүйтэй.

35. Өмгөөлөгч үргэлжлүүлэн, хэрэв Компани болон ХТБ нь тухайн хөрөнгийн үнэлгээний талаар нарийвчилсан мөрдөн шалгалтын ажиллагааг явуулаагүй эсвэл Шүүхийн шаардлагыг хангаж чадах тэдгээрийн Удирдах Албанаас шаардсан шаардлагатай арга хэмжээг аваагүй тохиолдолд Компанийн нэр дээр хөрөнгө байна хэмээв. Тэрээр ХТБ-ийн Шүүхэд гаргаж өгсөн баримт бичгийн зохисгүй бас хангалтгүй байдал, гуравдагч этгээд эсвэл зээлдүүлэгч талуудаас нэмэлт мэдээлэл авахын оронд ноён Ли-г мэдээллийн эх сурвалж болгон үндэслэсэн явдалд суурилсан. Тэрээр мөн Шүүхээс ХТБ-ийн тайланд олон тооны баримт бичиг дурдагдсан байх авч Шүүхэд ирүүлээгүй байгааг анхааралдаа авах талаар хүсэлт тавьсан.

36. Өмгөөлөгч татан буулгах шийдвэрийн үр дагавар нь томоохон үр дагавартай, Компанийг бүрмөсөн дуусгавар болгож, зээлдүүлэгч болон хувьцаа эзэмшигчдийн бүх нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож устгана гэдгийг харгалзаж үзэхийг Шүүхээс хүссэн.

37. Ноён Лигийн нэрийн өмнөөс энэ асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаархи Өмгөөлөгчийн гаргасан мэдүүлгийг би өргөн хүрээнд хүлээн зөвшөөрч байна. Энэ асуудлын гол нь хууль эрх зүйн болон бодитой фактгай асуудлууд юм. Сайн дурын татан буулгах ажиллагааны хүрээнд ***In re London болон Caledonian Marine Insurance Компани-***ийн иш татсан кейс, тохиолдол нь босгоны хувьд хэрэгтэй зааварчилгаа өгдөг. Энэ тохиолдолд хүсэлт гаргагчид өмнө нь сайн дурын үндсэн дээр татан буулгагчид компанийг татан буулгаж байсныг үл харгалзан Шүүхийн шийдвэрээр Компанийг татан буулгахыг хүссэн. Тэд компанийг бүрэн дуусгавар болгох нь татан буугдах урьдчилсан нөхцөл гэж үзэн өргөдлөө хэрэгсэхгүй болгосныг давж заалдсан. Компанийн мэдэгдэлд байсан өрийг барагдуулаагүй байхад компанийн хэрэг бүрэн дуусгавар болсон гэх

боломжгүй, мөн цаашдын нэхэмжлэлийг нөхөн төлөхийн тулд татан буулгагчдын гарт мөнгө үлдээсэн компанийн хөрөнгийг захиран зарцуулсан гэж хэлэх боломжгүй хэмээн мэдүүлжээ.

38. Давж заалдах шатны шүүх "***In Re Pinto Silver Mining Company***" компанид[16] холбогдох хэргийн өмнө нь гаргасан шийдвэрээ дурдаж, Мастер Ролл буюу шүүхийн дээд албан тушаалтны шийдвэрийг зөв гэж үзэн, давж заалдах гомдлыг хэрэгсэхгүй болгожээ. Шүүхээс "*Компанийн хэрэг бүрэн дуусгавар болмогц*" гэсэн үгэнд бодитой, ухаалаг утгыг илэрхийлэх ёстой гэж үзсэн бөгөөд энэ нь "*татан буулгагчид тэдгээрийг дуусгах, зогсоох боломжтой*" гэсэн утгатай юм. Ингэхдээ Шүүхээс:

> *"Шүүх нэгэнт асуудлыг шийдвэрлэсэн тохиолдолд нэхэмжлэлийн талуудын нэрсээс илүү шийдвэрийн бодит зүйлд бараг ялгаагүй материаллаг бус ялгаагаар дахин маргах ёсгүй гэдэг нь ойлгомжтой хэрэг; мөн миний дурьдсан хэрэг дээр шийдвэрлэсэн зүйл бол тухайлбал барилга угсралтын ажлыг урьдчилан тавигдах нөхцөл болгож, хийх ёстой бүх зүйл хийгдсэн гэсэн үг гэж тайлбарлахдаа бид "компанийн ажил хэрэг бүрэн дуусмагц" гэсэн үгсийг хэлж, үүнийг хийх ёстой бүх зүйл хийгдсэн гэж ойлгож болохгүй. Бидний үзэж буйгаар эдгээр үгс нь хэрэв хөрөнгийн өрийн үлдэгдэл, эсвэл төлөгдөөгүй ганц өр байгаа тохиолдолд компанийн үйл ажиллагааг дуусгавар болгосон гэж үзэх ёсгүй гэсэн үг биш.*
>
> *Төлбөрийн чадваргүй компанийн хэргийн кейсийг авч үзвэл тухайн үед төлбөрөө төлөөгүй шимтгэл төлөгчид байсан учраас төлбөрийн чадваргүй; эсвэлшимтгэл төлөгчийн эрэг шүүхийн шийдвэр гарсан гэж бодъё, мөн тэдэнд хөрөнгө байхгүй гэсэн шерифийн өгсөн мэдүүлэг, мөн тэрээр шүүхийн шийдвэрийн хэмжээг ногдуулах боломжгүй гэх, ийм зүйл үргэлжилсээр байвал компанийг бүрэн татан буулгах боломжгүй гэж хэлж болох уу? Эсвэлтүрээсийн гэрээний үлдэгдэл өр төлбөртэй, гэрээний дагууКомпани хэдэн жилийн дараа хариуцлага хүлээх боломжтой гэж бодож үзье, Компани бүрэн татан буугдаж чадаагүй гэж үү? Бид үгний бодитой, ухаалаг утгыг ашиглан тавих ёстой бөгөөд миний бодлоор эдгээр нь "татан буулгагчид тэднийг салгаж чадахын хэрээр" гэсэн утгатай; мөн татан буулгагч нь компанийг татан буулгахын тулд чадах бүхнээ хийсэн, өөрийн чадах чинээгээрээ хөрөнгөө захиран зарцуулсан, дуудлагад хүрч чадах чинээгээрээ харцуу өгсөн, мөн өөрийн мэдэж байгаагаар өрийг төлж, компанийн үйл хэргийг зогсоохын тулд чадах*

[16] 8 Ch.D.273

бүхнээ хийсэн, чадах чинээгээрээ ажлаа дуусгасан байх бөгөөд ингэх нь албан ёсны хийх ёстой ажил буюу functus officio юм."

39. Энэ хэргийн бодит асуудлууд нь Шүүхэд байршсан бүх нотлох баримтыг сайтар судалж үзэхийг шаарддаг. ХТБ-ийн нотлох баримтыг сайтар шалгаж, зохих шалгалт хийхгүйгээр хүлээн авах ёсгүй. Ялангуяа энэ тохиолдолд тэд шаардлагатай лавлагаагаа хийгээгүй, гүйцэтгээгүй бөгөөд нэг зээлдүүлэгчийг нөгөөгөөс нь илүүд үзэхийг хүсч байгаа өргөдлийг эсэргүүцэж байна. Шүүх хойш нь зогсож, өмнө байрлуулсан бүх материалд бодитой дүгнэлт хийх ёстой. Шүүх мөн авч үзэхэд тус дөхөм болохуйц, хараагүй үзээгүй байж болох материал байгаа эсэх талаар ямар нэгэн шинж тэмдэг байгаа эсэхийг харгазлаж үзэх ёстой.

ii) Ноён Лигийн хариу үйлдэл ба хариулт

40. ХТБ-ийн нэрийн өмнөөс тэдгээрийг төлөөлж буй өмгөөлөгч ноён Лигийн хариулт, хариу үйлдэл хариу арга хэмжээний тухай асуудлыг хөндсөн. Нотлох баримтаас харахад ХТБ нар түүний хэлсэн мэдэгдлийн баттай, найдвартай байдалд улам болгоомжтой хандах болсон нь харагдаж байна. Миний ойлгосноор түүний өгсөн мэдээллийн үнэн зөв эсэхэд санаа зовох ноцтой шалтгаан байгаа тухай хэлсэн. Ноён Лигийн нэрийн өмнөөс түүнийг төлөөлж буй өмгөөлөгч нь ноён Лигийн өгсөн мэдээлэл дундаас "өө сэв хайх"-саа илүү, ХТБ нар ноён Ли-ээс хэтрүүлэн лавлагааны цар хүрээг өргөжүүлэхгүй байх ёстой байсан хэмээн мэдүүлэгт хэсэгчлэн хариулав.

41. Ноён Коулейгийн мэдүүлгээр ноён Лигийн хийсэн зарим мэдэгдэл эсвэл нэхэмжлэлийг өмнөх мэдэгдэл эсвэл баримт материалтай зөрчилдөж байна гэх үндэслэлээр ХТБ хүлээн зөвшөөрөхгүй байгаа гэдгийг тодорхой харуулж байна. Тэд түүний өөр өөр тохиолдолд хийсэн мэдэгдлүүдийн хооронд хэд хэдэн зөрчил байгааг онцолж, түүний шалтгаан, сэдэлд асуултын тэмдэг тавьсаар байна. ХТБ-ын Өмгөөлөгчийн тодорхойлсон асуудлуудад дараахь зүйлс багтсан

42. 2019 оны 10-р сарын 8-ны өдөр ХТБ нартай хийсэн уулзалтаар ноён Ли Компанийн санхүүгийн таагүй байдлыг хүлээн зөвшөөрөв. Тухайн үед тэрээр PFL-ийн хувьцаа байгаа талаар мэдээлээгүй. Үнэн хэрэгтээ тэрээр PFL-ийн талаар ямар ч зүйл дурдаагүй бөгөөд Компани Хувьцаа эзэмших эрхтэй гэж огт дурдаагүй. ХТБ нарын өмгөөлөгч тэрээр ХТБ-д Компанийн авах эрхтэй үнэт хөрөнгө гэж дараа нь хэлж байгаа зүйлээ тэр үед хэлэхгүй байсан нь гайхмаар

юм гэж мэдэгдэв.

43. Ноён Ли ХТБ-д санхүүгийн таагүй байдлыг хүлээн зөвшөөрсөнөөс хойш сар хүрэхгүй хугацаанд SGL-тэй хийсэн олон удаагийн уулзалтууд болон 2019 оны 11-р сарын 4-ний өдрийн EGM зэрэг энэ бүх хугацаанд, ноён Ли татан буулгах анхны шүүх хурал болохоос өмнөх өдөр хүртэл эд хөрөнгө байгаа болон шилжүүлгийн талаар ХТБ-тай ярилцаагүй.

44. 2019 оны 12-р сарын 17-ны өдрийн ноён Лигийн хоёр дахь Баталгааны бичигт тэрээр шилжүүлгийг 1.00 Хонгконг доллараар хийсэн бөгөөд шилжүүлэг нь өөрийн үзэмжээр хийгдсэн байсныг өмгөөлөгч мөн онцолсон. Тухайн үед 2015 оны Төлбөрийн Гэрээний дагуу шилжүүлэг хийсэн талаар огт дурдагдаагүй. Дараа нь гаргасан бүртгэлээр ноён Ли SGL-ийн цорын ганц захирлын хувьд EGM-ийг даргалж байсныг харуулж байна. Хурлын протоколын 3 дахь хэсэгт тусгай тогтоолыг дараах байдлаар дэлгэрэнгүй өгүүлэв:

> *"Компанийн эзэмшиж буй Peace Fame Limited-ийн бүх хувьцааг Ланг Минг Майнинг Лимитед (Ланг Минг)-д нэрлэсэн 1.00 Хонгконг долларoop шилжүүлэх, эсвэл шилжүүлэхийг өөрийн үзэмжээр шийдвэрлэхийг Компанийн захирлуудад (захирлуудад) санал болгож, тэдгээрт эрх олгох"*

45. Иймхүү анхан шатны тараах, татан буулгах сонсгол шүүх хурлын дараа ХТБ нар шилжүүлгийг бэлэг болгон өгсөн гэсэн үндэслэлээр ажлаа үргэлжлүүлэв. Хоёр дахь удаагийн татан буулгах сонсголын өмнө ноён Ли гурав дахь удаагаа Баталгаа мэдүүлгээ гаргасна бөгөөд 2015 оны Төлбөрийн Гэрээний үр дүнд шилжүүлэг хийгдсэн бөгөөд PFL-ийг SGL-д шилжүүлэх нь энэхүү Гэрээний нөхцөл байсан, 2015 оны 10-р сарын 15-ны дотор CDB-д төлбөрийг төлж барагдуулаагүй бол хувьцааны эзэмшил Компанид буцаж очих байсан гэж мэдэгджээ..

46. Мөн ноён Ли Компанийн үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн бүтцийг төөрөгдүүлсэн байж болзошгүй гэж Өмгөөлөгч мэдэгдэв. Тэрээр өөрийн баталгаа мэдэгдэлдээ нэг талаас уг Хөрөнгө нь өөрөө Компанийн өмч байсан, нөгөө талаас SGL-д шилжүүлсэн PFL-ийн хувьцаа нь Компанид буцаж очих хөрөнгө байсан гэж хэлсэн.[17]

47. Түүнчлэн ноён Лигийн өгсөн баримт бичигт PFL-ийн хариуцлагын талаарх

[17] Гурав дахь Баталгаажуулах Мэдэгдэл 2020 оны 1 дүгээр сарын 23, 5 ба 8(b) Хэсэг; Дөрөв дэх Баталгаажуулах Мэдэгдэл 2020 оны 1 дүгээр сарын 24, 5 Хэсэг

мэдэгдэл болон түүний өмнөөс AP Appraisal Limited-ээс гаргаж өгсөн үнэлгээ хоорондоо зөрчилтэй байна. Эдгээрийг доор дэлгэрэнгүй тайлбарлах болно.

48. Миний бодлоор эдгээр процессын явцад ноён Лигийн үйл ажиллагаа, ХТБ-д өгсөн хариу үйлдэл, хариулт нь түүний хэрэгт нэмэр болоогүй нь гарцаагүй. 10-р сард ХТБ нартай уулзахдаа тэр PFL-ын хувьцаа, Эрээний Хөрөнгийг дурдаагүй байсан нь гайхмаар. Энэ тухайд ХТБ-ийн нэрийн өмнөөс гаргасан саналууд нь нэмэр үзүүлсэн. Гэсэн хэдий ч Шүүх энэ асуудалд ямар нэгэн нөлөө үзүүлж байгаа эсэх, хэр зэрэг нөлөөлсөн эсэхийг сайтар судлах ёстой.

iii) PFL-ийн хувьцаа шилжүүлгийн Хүчинтэй байдал

49. Хамтарсан гол асуудал нь PFL-ийн хувьцаа шилжүүлгийн хүчинтэй байх явдал байв.

50. ХТБ-ийн нэрийн өмнөөс тэдгээрийг төлөөлж буй Өмгөөлөгч нь энэ шилжүүлгийг Компани аль хэдийн Албан ёсоор Татан буугдаж байх үед хийсэн гэж үзсэн тул аливаа шилжүүлгийг зөвхөн ХТБ хууль ёсны дагуу хийх боломжтой байсан гэв. Харин үүний оронд тэдгээрийн мэдээгүй байхад хийгдсэн байсан. Өмгөөлөгч цааш нь үргэлжлүүлэн, ноён Лигийн авсан Хонгконгийн Хуулийн талаарх дүгнэлтэд шилжүүлгийг хүчинтэй гүйцэтгэхийн тулд шилжүүлэгч болон шилжүүлэн авагч хоёр гарын үсэг зурсан байх ёстой гэжээ. Энэхүү дүгнэлт нь шаардлага хангахуйц мэдэгдэл байх ба учир нь ноён Ли Компанийг төлөөлөн баримт бичигт гарын үсэг зурах эрх олгосон эсэхээс хамаарна. Түүнчлэн, корпорацийн үйл ажиллагааны хүчинтэй байдлын хувьд эдгээр нь компаниудын байгуулагдсан газрын харьяалагдах харьяаллын дагуу зохицуулагддаг. Ноён Ли нь CWR-ийн дагуу гарын үсэг зурах эрхгүй байсан тул Хувьцааны хэрэглүүрийг Компани хэрэгжүүлээгүй бөгөөд Хонгконгийн хуулийн дагуу шилжүүлгийг ХТБ гүйцэтгээгүй гэх үндэслэлээр хүчингүй байсан.

51. Ноён Коулей Дөрөв дэх мэдүүлэгтээ мөн Их Британийн Виржинийн арлуудаас ирүүлсэн санал дүгнэлтийг шилжүүлэг хийсний дараа өгсөн, гүйлгээний арилжааны байдлаар талаар, Компани нь Хонгконгийн хуулийн дагуу 2019 оны 12-р сарын 4-нд PFL-ийн цорын ганц гишүүн болсон гэх зэрэг олон таамаглалд өртсөн тухай тайлбар хийгээгүй зэрэгт санаа зовж буйгаа илэрхийлэв.

TRANSLATION BUREAU

52. Ноён Лигийн нэрийн өмнөөс түүнийг төлөөлж буй Өмгөөлөгч нь хэлэхдээ, Хувьцааг эзэмшиж эхлэх цэг нь шилжүүлэг бус хэдий ч, шилжүүлэх чадваргүй байсан ч одоо энэ нь нэгэнт Бүртгэлд бүртгэгдсэн байгаа зүйл. Хууль ёсны эрх нь бүртгэгдсэн эрхээс үүсэлтэй байх бөгөөд өмчлөх эрхийг Гишүүдийн Бүртгэлд бүртгэсний дараа шилжүүлгийн хүчингүй болох нь хамаагүй болно гэж тэр хүчтэй маргав. Одоо ХТБ нарын хувьд тавигдах асуулт бол үүнийг буцаах ёстой юу, чухал асуудал нь өөр хэн нэгэн асуудал, маргаангүй гэдгээ харуулж чадах эсэх явдал юм. Энэ нь хэн нэгний хувийн үзэл бодлоос хамаарахгүй, харин эргэлдэж хүрээлж буй баримт материалаас хамаарна.

53. Өмгөөлөгч 2019 оны 12-р сарын 4-ний өдөр нэг Хувьцааг[18] шилжүүлсэн болохыг харуулсан Компанийн Гишүүдийн Бүртгэл зэрэг авагдсан баримт нотолгоонуудыг иш татав. Өмгөөлөгч мөн хувьцааг 2011 оны 3-р сараас эхлэн шилжүүлсэн компаниудын эзэмшил, шилжүүлгийн хэлхээ, хэзээ Хувьцаа байсан, хэзээ SGL-ийн бүртгэлд болсоныг онцлон тэмдэглэсэн.

54. Компанийг хувьцааны хууль ёсны эрхтэй болохыг нотлох баримтууд Бүртгэлүүдэд тусгасан байх бөгөөд тавигдах асуулт нь өөр компанид тэгш эрх ашиг байгаа эсэх, харин ХТБ-ын хувьд SGL-ийн нэхэмжлэлийг эсэргүүцэх хангалттай эрх ашиг байгаа эсэх асуудал мөн хэмээн Өмгөөлөгч өгүүлэв. Өмгөөлөгчийн хэлсэн гол суурь зүйл нь Бүртгэлд байгаа хүн буюу энэ тохиолдолд Компани нь Бүртгэлийг засч залруулахаас бусад тохиолдолд, засч залруулах хүртэл хууль ёсны нэр, байр суурь албан тушаалтай гишүүн байх явдал юм.

55. Өмгөөлөгч мэдүүлэгтээ дэмжлэг үзүүлж хүч нэмэх үүднээс, ***Nilon Ltd*-ийн эсрэг *Royal Westminster Investments SA*-**ийн хэргийг[19] дурдаж, бүртгэлийг засварлах журмын талаархи дараах хэсгийг онцлон тэмдэглэв;

> *"Хууль тогтоомж нь хууль ёсны эзэмших эрхийн асуудлыг юуны түрүүнд харгалзан авч үздэг гэдэгт эргэлзээ үгүй. Re London, Hamburgh and Continental Exchange Bank, Ward and Henry's Case (1867) LR 2 Ch App 431 Lord Cairns LJ кейст энэ хэсгийн зорилго нь компанийн ашиг хүртэх эрхтэй, өр төлөх үүрэгтэй хувьцаа эзэмшигчид хэн болохыг харуулсан жагсаалт, бүртгэлийг баталгаажуулах явдал юм (440-д) гэж хэлэхэд ойлгомжтой гэж үзэж болох зүйлийг дурдсан. Их Британийн Виржинийн Арлууд болон Их Британийн аль алиных нь хууль тогтоомж*

[18] Ноён Лигийн Хоёр дахь Баталгаажуулах Мэдэгдэл 2019 оны 12 дугаар сарын 17, Баримт XI-2, 175х
[19] 2015 UKPC 2

нь гишүүдийн бүртгэлийг засахыг авч үздэг бөгөөд гишүүнчлэл нь хууль ёсны эзэмших эрхтэй холбоотой байдаг: Enviroco Ltd v Farstad Supply A/S [2011] UKSC 16, [2011] 1 WLR 921, 37-38 дугаар зүйлд Лорд Коллинз хэлэхдээ:

"37. 2006 оны Актын 112-р хэсэгт байгаа "гишүүн" гэсэн тодорхойлолт нь эхлэх цэг нь ба... Нэгдсэн Вант Улсын компанийн тухай хуулийн үндсэн зарчмыг тусгасан бөгөөд тухайлбал, эрэгээр нь тодорхой заагаагүй бол, гишүүдийн бүртгэлд байгаа хүн нь бусад этгээдийг эс тооцвол гишүүн байх; бүртгэлийг засахаас бусад тохиолдолд: In re Sussex Brick Co [1904] 1 Ch 598 (бүртгэлийг буцаан засварлах нь мэдэгдлийг хүчингүй болгоргүй).

38. Компанийг нэгтгэх тухай хууль 1845 (8 ба 9 Vict c 16) болон Компанийн тухай хууль 1862 (25 & 26 Vict c 89) гарсанаас хойш гишүүдийн бүртгэлд бүртгүүлэх замаар гишүүнчлэлийг тогтоосон. Компанийн хууль тогтоомж энэ үндсэн дээр хэрэгжиж байгаа бөгөөд хэрэв тийм биш байсан бол ажиллах боломжгүй болно ... "

56. ***Nilon Ltd-ийн эсрэг Royal Westminster Investments SA***-ийн хэрэг нь Бүртгэлийг засч залруулах хураангуй ажиллагаатай холбоотой гэдгийг Өмгөөлөгч цохон тэмдэглэж, Удирдах зөвлөл нь өмчлөлийн талаар маргаан гарсан тохиолдолд дүгнэлтийн процессыг зохистой бус гэж үзээд, хувьцааг шууд эзэмших эрхгүй бол татгалзах тохиромжит зөв арга нь ердийн үйл ажиллагааны арга юм. Энэ нь хэрэв Гишүүдийн Бүртгэлд компани биш өөрөө байх ёстой гэдгийг тогтоохыг оролдсон бол Өмгөөлөгчийн хэлсэнээр SGL компани Кайманы арлууд дахь компанийн эсрэг нэхэмжлэл гаргах шаардлагатай гэсэн үг юм.

57. Өмгөөлөгч олон тооны нэмэлт хэргүүдийг дурьдсан бөгөөд үүний үр нөлөө нь Хувьцааны Бүртгэлд шилжүүлсэн тэмдэглэл бичлэгийн ачаар ХТБ нар хүчтэй байр суурьтай байгааг нотлохыг оролдсон. Эдгээрт ***Svanstrom and Nine Others v Jonasson***[20] хэрэг багтсан. Энэ нь аль нэг тал нь зөвхөн ашиг хүртэгч өмчлөгч бол дериватив нэхэмжлэл гаргах эрхгүй болохыг баталж байна гэж өмгөөлөгч мэдэгдэв. Кайманы арлуудын Давж заалдах шатны шүүх (CICA) Хариуцагч нь 7дахь ба 8 дахь Давж заалдах этгээдийн цөөнхийн хувьцааны бенефициар эзэмшигчийн хувьд компанийн нэрийн өмнөөс захирлынхаа эрэг нэхэмжлэл гаргах эрхгүй байр суургүй (locus standi) гэж тогтоосон. Тэрээр аль ч компанийн бүртгэлтэй гишүүн биш байсан бөгөөд энэ асуудал нь тогтоосон хязгаарласан

[20] 1997 CILR 192

зүйлүүдийн алинд ч хамаарахгүй.

58. ***Natural Dairy (NZ) holdings Limited***-ийн[21] асуудлаар Дээд шүүхээс зөвхөн бүртгэлтэй хувьцаа эзэмшигчид татан буулгах хүсэлт гаргах эрхтэй гэж үзсэн. Хувьцаа эзэмшигчийн байр суурь нь хууль ёсны эрх олгосон бүртгэлээс хамаарна.

59. ***Societe Generale de Paris Colladon болон Janet Walker***-ийн[22] хэрэг нь тодорхой хувьцааг хэн эзэмшдэгтэй холбоотой маргааныг авч үзсэн. Бүртгэл хийхгүйгээр өмчлөх эрхийг бүрэн авах боломжгүй, тухайн хүн Шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй, хувьцаанд хууль ёсны эрх олгох боломжгүй гэж Шүүх үзсэн. Гомдол гаргагч нь Скотт Уолкер[23] хэмээх нэр хүндтэй цолыг даван туулах хангалттай тэгш эрхтэй биш гэж дүгнэсэн.

60. Өмгөөлөгчийн гаргасан мэдүүлгийн үр нөлөө нь миний ойлгосноор, ХТБ-ийн тавьсан гол асуулт нь шилжүүлэг хүчинтэй эсэх бус, харин шилжүүлэг бүртгэлд бүртгэгдсэн байсан ч тэд "*хангалттай тэгш эрхтэй нэхэмжлэл байсан эсэх эсвэл мөрдөн шалгалтын ажиллагаа явуулах хэмжээний нэхэмжлэл байсан эсэх*" байсан буюу үүнийг дагаж мөрдөх ёстой бөгөөд энэ нь өмчлөлийн талаар бусад аж ахуйн нэгжүүд эсэргүүцсэн тохиолдолд амжилттай няцаалт, эсэргүүцэх боломжийг хэмжих боломжийг олгоно.

61. Өмгөөлөгч дараа нь Компани ямар замаар эрх тэгш эрхтэй болж байгаа нь чухал асуудал бөгөөд үүний үр дүнд 2015 оны Төлбөрийн Гэрээ нь Компанид PFL-ийн хувьцааг эсэргүүцэх чадвартай байхын тулд хангалттай тэгш эрх олгох эсэх нь гол асуудал юм.

iv) 2015 оны Төлбөрийн Гэрээ

62. 2015 оны Төлбөрийн Гэрээний үр нөлөөний талаар санал зөрөлдөөн их байна. Нэмэлт өөрчлөлтөөр оруулсан Зүйл заалт 2.8(b) нь дараах байдалтай байна:

> *"Хэрэв CDB-ны зориулалтын данс нь цуцлах өдөр буюу түүнээс өмнө CDB-ны эргэн төлөлтийн дүнг бүхэлд нь хүлээн аваагүй бол хяналтын хувьцаа эзэмшигч, Тусгай зориулалтын компани Ланг Минг, Айрон*

[21] (2017) 1 CILR Тэмдэглэл 3
[22] 1885 11 APP. Cas.20
[23] Шийдвэр 27-31х

Майнинг Интернэшнл, Шайни Глоу болон Худалдан авагч нар 2016 оны 7 дугаар сарын 15-ны өдөр яаралтай арга хэмжээ авна (эсвэл CDB-ны өөрөөр бичгээр тохиролцсон дараагийн өөр бусад өдөр) Айрон Майнинг Интернэшнл, Шайни Глоу компанийн хувьцааны өөрчлөн байгуулалт болон бусад хэлцлийн улмаас Ланг Минг, Айрон Майнинг Интернэшнл, Шайни Глоу компанийн хувьцааны бүтцэд гарсан өөрчлөлтөд хариу өгнө. Гүйлгээний үндсэн баримт бичигт гарын үсэг зурахаас өмнөх статусыг сэргээнэ (үүнд Ланг Минг, Айрон Майнинг Интернэшнл болон Шайни Глоу компанийн бүх хувьцааг эргүүлэн авч, эзэмшиж байсан (үүнд=цаашид "Хувьцааг эргүүлэн буцаах" гэх) ". Гэсэн хэдий ч ..."[24]

63. Гэрээний талууд[25] нь ноён Ли, (Хяналтын хувьцаа эзэмшигч), Чен Цай Шиа, Тусгай зориулалтын Компани[26] (Монголын Ерөө гол төмөр and Айрон Майнинг Хязгаарлагдмал, Сити Форд Лимитед, Саксэсфул Ки Лимитед-ээс бүрддэг), Айрон Майнинг Интернэшнл (Монголиа) Лимитед, SGL, Жунг рунь Ресурс Хөрөнгө оруулалтын корпораци болон CDB юм.

64. ХТБ-ын өмгөөлөгч ноён Лигийн санал болгож буй хэлцэл нь PFL-ийн хувьцааг шилжүүлэх нь Төлбөрийн Гэрээнд тусгагдсан хувьцааг буцаах ажил биш гэж мэдэгдэв. Бүтцийн өөрчлөлтийн гэрээ хийхээс өмнө PFL хэзээ ч Компанийн мэдэлд байгаагүй гэсэн бодит байр суурьтай байна гэж тэр хэлэв. Энэ нь SGL-ийн эзэмшилд байсан.

65. Өмгөөлөгч мөн ноён Лигийн гаргасан 2014-2018 оны PFL-ын санхүүгийн тайланд Шүүхийн анхаарлыг хандуулав. 2014 оны санхүүгийн тайлангийн тэмдэглэл нь PFL-ийн өмчлөлийг илэрхийлдэг. Үүнд:

"Пийс Фейм Лимитед ("Компани") нь хувийн хязгаарлагдмал компани бөгөөд 2011 оны 2-р сарын 7-нд Хонгконгд үүсгэн байгуулагдсан. Захирлууд нь Британийн Виржинийн арлуудад бүртгэлтэй Шайни Глоу Лимитед компанийг Компанийн шууд эзэмшигч компани, Кайманы арлууд дахь Ланг Минг Майнинг Хязгаарлагдмал Компанийг Компанийн эцсийн эзэмшигч компани гэж үздэг"[27]

Тиймээс тухайн үед PFL нь эцсийн дүндээ Компанийн мэдэлд байсан SGL-ийн

[24] Баримт XL-4, 5х
[25] Баримт XL 3, 217-219х
[26] Гэрээний Хавсралт 2-т тодорхойлсон - Баримт XL 3, х 232
[27] Баримт XL-3, 27х

мэдэлд байсан гэж маргаж байна.

66. Гэсэн хэдий ч 2015 онд дуусгавар болсон жилийн PFL санхүүгийн тайлангийн тэмдэглэлд "захирлууд SGL-ийг тайлант хугацааны эцэст компанийн шууд бөгөөд эцсийн эзэмшигч компани гэж үзэж байна" гэж заасан.[28] Өмгөөлөгч одоогоор энэ асуудлаар компанийг дурдаагүй гэдгийг тэмдэглэж байна. ХТБ-ын хэлсэнээр бол бодит байдал дээр SGL тэр үед Компанийн мэдэлд байхаа больсон байсан. Бүтэц өөрчлөгдсөн бөгөөд Компани нь SGL-ийг эзэмшихийн оронд SGL болон PFL хоёуланг нь Компаниас шилжүүлэн гаргасан.

67. Өмгөөлөгч мөн олж авсан санхүүгийн тайлангаас харахад SGL нь төлбөрийн чадваргүй мэт харагдаж байгааг онцолсон. 166 сая ам.долларын нэхэмжлэлтэй мөн CDB[29]-ийн өртэй. Энэ нь PFL-ийн хувьцааг SGL-ээс Компанид шууд шилжүүлэх нь Төлбөрийн Гэрээнд тусгагдаагүй байсан SGL түвшинд байгаа нэхэмжлэлийг үр дүнтэйгээр бууруулж, түүнийг тойрч гарах болно гэсэн үг юм.

68. Ноён Лигийн нэрийн өмнөөс түүнийг төлөөлж буй өмгөөлөгч нь хэлэхдээ, хэрэв SGL нь Төлбөрийн Гэрээний дагуу хувьцаагаа Компанид буцааж шилжүүлэх үүрэг хүлээсэн бол энэ нь SGL хувьцааг эрхийн эзэмшлээ эсэргүүцсэн тохиолдолд Компани найдаж болох хувьцаанд эрх тэгш ашиг хүртэх үндэс суурь болдог.

69. Гэрээ нь үнэн хэрэгтээ PFL-д хамаарахгүй бөгөөд PFL түүнд нэг тал биш гэж мэдэгдсэний хариуд ноён Лигийн өмгөөлөгч гэрээ нь иж бүрэн биш гэж мэдэгдэв. Өөрчлөлт оруулсан 2.8-д "*багтсан боловч үүгээр хязгаарлагдахгүй*" гэсэн үг байгааг тэрээр онцоллоо. Мөн PFL-г багтаагүй гэж хэлж болохгүй, энэ нь зүгээр л мэдэгдэхгүй бөгөөд дахин шилжүүлэх үүрэг хүлээсэн нь Гэрээг харах бүрэн дүр зургийг мэдэж байгаа гэсэн үг биш юм.

70. Ноён Лигийн нэрийн өмнөөс түүнийг төлөөлж буй өмгөөлөгч нь Гэрээний үг хэллэгээс PFL-ийн Хувьцаа үүнд багтсан эсэхийг мэдэхгүй гэдгээ хүлээн зөвшөөрсөн хэдий ч, ХТБ нар үүнийг ноён Лигийн Баталгаажуулалт мэдүүлгээс мэдэж болох байсан гэв. Өмгөөлөгч ноён Лигийн нотлох баримтуудыг дурдаж, PFL анх Компанийн эзэмшилд байсан бөгөөд Төлбөрийн Гэрээний үр нөлөө нь

[28] Баримт XL- 3, 47х
[29] Ноён Ли ХТБ нарт боловсруулж өгсөн баримт материал Баримтын 65х, Патрик Коулейгийн Дөрөв дэх удаагийн мэдүүлэг

хувьцааг эргүүлэн авах[30] боломжтой гэдгийг нотлох баримтдаа гурван удаа давтан хэлсэн. Ли PFL-ийн хувьцаа Компанид буцаж очно гэж өгүүлж байхдаа хууль ёсны эрх биш харин тэгш эрхтэй байх эрхийг өгүүлж байсан байх ёстой бөгөөд хэрвээ Гэрээ нь үнэн хэрэгтээ PFL-тэй холбогдож байвал эрх тэгш эрх нь Компанид буцаж очих ёстой гэв.

71. Өмгөөлөгч мөн энэ талаар нэмэлт тайлбар хийж, Хонг Конгийн хууль тогтоомжийн дагуу Гэрээг тайлбарлахын тулд гадны нотлох баримтыг харж болно гэдэгт эргэлзэж байгаагаа илэрхийлсэн боловч ноён Ли бусад нотлох баримттай зөрчилдөөгүй эсвэл маргаангүй гадны нотлох баримтуудыг өгсөн байдаг хэмээв. Гэрээнд оролцсон бусад байгууллагууд хэзээ ч ийм сонирхол байгаагүй гэж хэлэх байх гэж тэр уриалав. Энэ талаар өөр мэдэгдэл хийгээгүй тохиолдолд, бас ноён Ли зөрчилдөөгүй бол, PFL-ийн хувьцааны хувийг шилжүүлэх үүрэгтэй байсан бөгөөд Гэрээ нь Компанид PFL-ийн Хувьцааны өмчийг өгсөн.

72. Дүгнэж хэлэхэд, Өмгөөлөгч нь ХТБ-ын хийсэн ажил нь өнгөцхөнтөдий байсан гэж үзэж, тэднийг:

a) Зөвхөн ноён Литэй ярьж, түүнээс бүх асуултыг асууж байсан.
b) 2015 оны Бүтцийн өөрчлөлт, Гэрээнд оролцсон зээлдүүлэгчдээс мэдээлэл, бичиг баримт авах зэрэг арга хэмжээ авах, нэмэлт лавлагаа хийхгүйгээр нотлох баримтыг эсэргүүцсэн.
c) Эдгээр асуудалд оролцогч талууд болох тэр дундаа CDB зэрэг сонирхогч талын нотлох баримттайгаар ноён Литэй зөрчилдөх, няцаах оролдлого хийгээгүй.

73. Ноён Лигийн нэрийн өмнөөс түүнийг төлөөлж буй Өмгөөлөгч нь буулт хийж байгаа нь надад зүйтэй санагдсан бөгөөд баримтууд нь түүний гаргасан мэдүүлгийн хүчийг сулруулж байна. Гэрээг нягталж үзэхэд, гаднаасаа бол PFL нэг тал биш. [31]Бүр цаашилбал, 2.8(b)-д PFL-ийн хувьцааг[32] шилжүүлэх бус SGL-ийг Компанид буцааж шилжүүлэх тухай заасан байдаг. Гэрээнд PFL-ийн хувьцааг Компанид дахин шилжүүлэх шаардлагагүй юм шиг харагдаж байна. Ноён Лигийн нотлох баримтыг түүний өөрийнх нь гаргаж өгсөн баримт бичгүүдээс тусад нь авч үзэж болохгүй. ХТБ-гийн тавьсан мэдэгдэл нь үндэслэл

[30] Гурав дахь Баталгаажуулах Мэдэгдэл 2020 оны 1 дүгээр сарын 23, 9 хэсэг, Дөрөв дэх Баталгаажуулах Мэдэгдэл 2020 оны 1 дүгээр сарын 23, 5 хэсэг,
[31] Баримт XL 3, 217-219х
[32] Баримт XL 3, 223х, 2.8(b) хэсэг

сайтай харагдаж байгаа бөгөөд Төлбөрийн Гэрээний нөхцөлийг шударгаар тогтоох арга хэрэгсэл болгон найдах нь хүчирхэг байр суурь болж өгөхгүй гэсэн үг юм.

v. Мөрдөн шалгалтын хамрах хүрээ

74. Ноён Лигийн Өмгөөлөгч ХТБ-ийн өөрийн тайланд нэмэлт мөрдөн шалгалт явуулах шаардлагатай гэж үзсэнийг тодорхой харуулж байгаа бөгөөд бүтцийн өөрчлөлтийн талаар ямар байр суурьтай байсан болон маргаантай хөрөнгийн талаарх байр суурийг өнөөг хүртэл тогтоогоогүй байна гэж маргав. Тэрээр ХТБ-ийн Эцсийн Тайлангийн хоёр хэсгийг онцолж, ХТБ шалгах шаардлагатай гэж үзсэн нь тодорхой байгаа бөгөөд яг зээлдүүлэгчид хаах шатанд шилжүүлэхийг эрэлхийлсэн нь тодорхой байна гэв.

75. Тус тайланд ХТБ нар зээлдүүлэгчид ямар нэгэн үнэ цэнийг гаргаж болохуйц өмч хөрөнгө байхгүй, мөн "*2015 оны бүтцийн өөрчлөлттэй холбоотойгоор нөхөн сэргээх боломжит стратегийг хэрэгжүүлэхийн тулд зээлдүүлэгчид ямар нэгэн санхүүжилт олгоогүй тохиолдолд татан буулгах үйл ажиллагааг хаахад шаардлагатай алхмуудыг идэвхтэй авч үзэх шаардлагатай болно*"[33] гэж зөвлөсөн тухай тэмдэглэв. Зээлдүүлэгчдийн хүсэлтээр 2015 оны бүтцийн өөрчлөлттэй холбоотой бэлэн байгаа баримт бичгүүдийг нягтлан үзэж, түүнийг буцаах талаар ямар арга хэмжээ авах талаар ХТБ авч үзэхээр хурлаар тохиролцсон. Татан буулгах Хорооны анхдугаар хуралдаан (Liquidation Committee буюу "LC" гэх) гэсэн гарчигтай Тайланд: -

> *"Хүсэлтийн дагуу ХТБ-ууд LC-ийн гишүүдээс өөрсдөд нь олгосон Гэрээг хянаж үзсэнээ тайлагнасан. ХТБ нар 2015 оны бүтцийн өөрчлөлттэй холбоотой хуулийн зөвлөгөөний үр ашгийг хараахан аваагүй байгаа бөгөөд ХТБ нармөн холбогдох гүйлгээний баримт бичгүүдийг бүхэлд нь хараахан хараахан хараахан олж хараагүй нь тодорхойгүй байсан. Гэсэн хэдий ч одоогийн байдлаар олж авсан баримт бичгүүдэд үндэслэн, Компани нь холбогдох гэрээ хэлэлцээрт оролцогч байсан тохиолдолд 2015 оны бүтцийн өөрчлөлтийг эсэргүүцэж, шүүхэд нэхэмжлэл гаргах боломжтой байх ёстой гэж ХТБ заажээ. Гэсэн хэдий ч ХТБ хоёр чухал анхаарвал зохих зүйлийг тэмдэглэсэн нь: (а) аливаа сорилт бэрхшээлийн ач тус, амжилтыг тодорхойлохын тулд хууль зүйн томоохон зөвлөгөө шаардлагатай болох байх, мөн(б) 2015 оны бүтцийн өөрчлөлтийг буцаах*

[33] Эцсийн Тайлангийн 3х 3 хэсэг, Баримт РС-2 20х, Баримт РС-2 20х

зорилгоор шүүхээр зарга үүсгэсэн нь үл хөдлөх хөрөнгийн зээлдүүлэгчид ямар нэгэн үр өгөөж авчрах нь тодорхойгүй байсан бөгөөд өнөөдрийг хүртэл ХТБ-д өгсөн гэрээнүүд болон хязгаарлагдмал мэдээлэлд үндэслэсэн. (Энэ нь бас зээлдүүлэгчид Айро Майнингийн зээлдүүлэгчийн хувьд боломжгүй байх болно."[34]

76. Өмгөөлөгч нь ХТБ нараас энэ зөвлөгөөг авах боломжгүй гэж хэлээгүй бөгөөд үүнээс үзэхэд LC-ийн гишүүдэд Шүүхэд гаргаагүй, үзүүлээгүй бичиг баримт байгаа нь илт байна гэж мэдэгдэв.

77. Мөрдөн шалгалт явуулах хэмжээний зүйл байгааг шийдэж олохын оронд ХТБ-ийн нотлох баримтууд нь ноён Лигийн мэдэгдэлд тавьсан асуултуудаас бүрдэж байна гэж тэрээр гомдолложээ. Баримт бичиг олгох хүсэлтийг ноён Ли хариуцах нь зөв биш, ноён Лигийн нотлох баримтыг няцаах үндэслэл байхгүй гэжээ.

78. Мэдээлэл өгөхдөө ноён Ли-д ихээхэн найдаж байна гэсэн ХТБ-ийн шүүмжлэлийг би үндэслэлгүй гэж үзэж байна. Захирал болон хуучин захирлын хувьд тэрээр үнэлгээ өгөхөд шаардлагатай мэдээллээр хангах хамгийн тохиромжтой албан тушаал, байр сууринд байсан. Мөн ноён Лигийн гаргаж өгсөн аливаа нотлох баримтыг олж авсан баримтат материалын цаана нягтлан үзэх нь нээлттэй гэж би үзэж байна.

79. Өмгөөлөгч ***Oughtred ба IRC***-ийн[35] кейсийг дурдсан ба энэ хэрэгтэх, хүү хоёрын хооронд өөрт нь хувьцаа шилжүүлэх тухай аман хэлцэл нь түүнд эдгээр хувьцааг тэгш эрхтэйгээр эзэмшихэд нөлөөлсөн эсэхийг авч үзсэн. Өмгөөлөгч нь Лорд Рэдклиффийн үндэслэл нь хүү нь ээжтэйгээ байгуулсан аман гэрээний дагуу буцаах эрх тэгш эрхтэй байсан, Учир нь гэрээ нь тодорхой гүйцэтгэлийг биелүүлэх ёстой эд хөрөнгөтэй холбоотой байсан гэдгийг онцолсон. Дараа нь хүү нь түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч болсон аж. Өмгөөлөгч мөн Лорд Женкинсийн шүүлтийг онцлон дурдсан, үүнд эрдэмт Шүүгч:

"Худалдан авах гэрээ байгуулсанаар худалдан авагчийн талд бий болсон итгэл үнэмшил нь худалдан авагчийн тодорхой гүйцэтгэлийн журмаар гэрээний хэрэгжилтийг хангах эрх дээр суурилдаг. Өөрөөр хэлбэл, түүнийг гэрээний дагуу худалдагчаас өөрт нь шилжүүлэх үүрэг хүлээсэн эд

[34] Эцсийн Тайлангийн 4х 7 хэсэг, Баримт РС-2 21х
[35] 1960 AC 206

хөрөнгийг гэрээний дагуу авах эрхтэй гэж үзнэ."

80. Өмгөөлөгч нь одоогийн хэрэгтэй адилтгах зүйл бол SGL-ийн эсрэг албадан гүйцэтгэх боломжтой эсэх, тусгайлан гүйцэтгэх боломжтой гэрээтэй байр суурьтай холбоотой гэж мэдэгдэв. ХТБ энэ асуудлыг бодитойгоор шалгаагүй бөгөөд 2019 оны 12-р сарын 4-нд хийсэн шилжүүлгийг буцаахгүй байх үндэслэлийг гаргаж өгөөгүй байна гэв.

81. Эцсийн тайланг гаргах үед 2019 оны 12-р сард ямар ч байр суурьтай байсан, гурав дахь удаагаа татан буулгах сонсгол шүүх хурлын үеэр ХТБ нарын мөрдөн шалгалтын түвшин зэрэг асуудал нэлээд урагшилсныг би тэмдэглэж байна.

vi. Эрхээсээ татгалзах

82. Ноён Лигийн нэрийн өмнөөс түүнийг төлөөлж буй өмгөөлөгч ХТБ нь эд хөрөнгөө татгалзахыг эрмэлзэж байсан бөгөөд энэ нь үүрэг хүлээсэн[36] хөрөнгө байсан гэж маргав. Кайманы аралд үүрэг хүлээсэн эд хөрөнгөтэй холбоотой зохицуулсан хууль байдаггүй. ХТБ-ийн нэрийн өмнөөс түүнийг төлөөж буй өмгөөлөгч хариуд нь онц үүрэг хүлээсэн эд хөрөнгийн талаар татгалзсан хариу өгсөн (point re disclaimer of onerous property) нь буруу ойлголт бөгөөд Кайманы арлуудад ийм өмчтэй холбоотой хууль байхгүй байгаа нь ямар ч хамааралгүй. ХТБ-ийн байр суурь бол өнгөн талаас нь харахад энэ нь үүрэг хүлээсэн хариуцлага бүхий өмч биш, PFL-ийн хувьцаа нь бусад зээлдүүлэгчдийг давж гарсан байнгын өр төлбөр үүсгэхгүй, Хувьцаа нь ХТБ-ийн үнэ цэнэгүй гэж үздэг өмч төдий юм. Би энэ тал дээр ХТБ-ийн аргументуудыг хүлээн зөвшөөрч байна. Энэ нь энэ хэргийн явцын ахиц дэвшлийн туршид тэдний гаргаж ирсэн нотлох баримтуудыг тусгал юм.

vii. Пийс Фейм Лимитед хувьцааны үнэ цэнэ

83. Хувьцааны үнэлгээтэй холбоотой маргаануудын гол хэсэг нь 2020 оны 3-р сарын 3-ны өдрий[37]н АР үнэлгээний үнэлгээ байсан. Үнэлгээний баримт бичигт зааснаар 2019 оны 12-р сарын 17-ны байдлаар PFL болон түүний охин компаниудын 100 хувийн өмчийн бодит үнэ цэнэ, үнэлгээг харуулж байна гэсэн байдаг. Зах зээл эсвэл орлогын аргаас илүү хөрөнгийн арга барилыг ашигласан.

[36] In Re Nottingham General Cemetry Co. (1995) 1 Ch.683
[37] Баримт РС 4, 50х

Компани одоогоор алдагдалтай ажиллаж байгаа тул ашиг олох санхүүгийн таамаг үнэн зөвийг баталгаажуулах боломжгүй гэж үнэлгээчин энэхүү сонголтыг тайлбарласан. Түүнчлэн шинэ үйлчлүүлэгчдээс олох орлого тодорхойгүй байна. Компани одоогоор алдагдалтай ажиллаж байгаа тул харьцуулж болохуйц зарчмаас гаргаж авсан зах зээлийн үржүүлэгчийг үнэ цэнийн талаарх дүгнэлт гаргах найдвартай үндэслэл болгон ашиглах боломжгүй тул зах зээлийн аргыг ашиглаагүй.[38]

84. Үнэлгээг дэмжих зорилгоор гаргасан үнэлгээний ерөнхий таамаглалд гол хувьцаа эзэмшигч нь хөрөнгийн эргэлтийн хэрэгцээг багтаасан ч үүгээр хязгаарлагдахгүйгээр компанийн одоогийн болон ирээдүйн бизнесийг дэмжих, хүүгүй санхүүжилт олгохыг тусгасан болно.[39]

85. Хийгдэж буй барилгын томоохон хэмжээний үл хөдлөх хөрөнгийн цэвэр үнэлгээ 106 сая ам.доллар дээр ирэхэдбогино хугацааны өр төлбөр худалдааны болон бусад өглөг нь 38,481,540.00 ам.доллар байсан. Энэ тоо нь ноён Лигийн ХТБ-д өгсөн зээлдүүлэгчийн нэхэмжлэлтэй нийцэхгүй байгаа тул 38,481,540.00 ам.долларыг үнэн зөв хэлэх боломжгүй гэдгийг ХТБ-ийг төлөөлж буй өмгөөлөгч онцолж байна. 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар PFL-д өгсөн зээлдүүлэгчийн нэхэмжлэлийн жагсаалтад 82,226,536.84 ам.доллар, Эрээний хувьд 93,650,087.00 ам.доллартай тэнцэх хэмжээний зээлдүүлэгчийн нэхэмжлэл гарсан байна.

86. Эдгээр нэхэмжлэлийг үл харгалзан Үнэлгээчин нь 38 сая ам.доллараас бага тоонд хэрхэн хүрч ирсэн талаар ямар ч тайлбар хийгээгүй. Тэдний авах боломжтой нэмэлт мэдээллийг харгалзсан үзсэний дагуу өр төлбөрийг тооцох үед цэвэр хөрөнгийн үлдэгдэл 24 сая ам.долларт хүрнэ гэсэн тул үнэлгээ нь 80% хүртэлх хэмжээгээр буруу байна гэж ХТБ дүгнэв.

87. ХТБ нар Үнэлэгчингээс ярилцлага авахыг эрэлхийлсэн. Үнэлгээчин ярилцлага өгөхөөс татгалзсан. 2020 оны 3-р сарын 17-нд ноён Лигийн нэрийн өмнөөс түүнийг төлөөлж буй Өмгөөлөгч ХТБ нарт хүсэлтээ бичгээр[40] ирүүлэхийг зөвлөсөн. ХТБ 2020 оны 4-р сарын 14-нд асуулга явуулах дараах асуудлын талаар бичсэн бөгөөд үүнд: -

а) Хувьцаа эзэмшигчийн дурдсан санхүүжилтийг хангах боломжтой гэсэн таамаглалыг шалгасан эсэх талаар аливаа нотлох баримт;

[38] Баримт РС 4, 53х, 1 хэсэг
[39] Баримт РС 4, 55х, 10 хэсэг
[40] Баримт РС 4, 60х

b) Үнэлгээчин нь эд хөрөнгөд хуучирч болзошгүй нөлөөллийг харгалзан үзсэн эсэх.

88. Үнэлгээчин нь төлбөрийн чадваргүй болон шүүхтэй холбоотой аливаа зорилгод зориулагдаагүй, зөвхөн дотоод хэрэгцээнд зориулагдсан гэж мэдэгдэн хариу өгөхөөс татгалзсан.

89. ХТБ нар мөн ноён Лигээс Эрээний өнөөгийн байдал, бизнесийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүссэн. Тэдний хүсэлтийн 15a.-f зүйлд уул уурхайн үйл ажиллагааны цар хүрээний талаарх мэдээлэл, уул уурхайн үйл ажиллагааны санхүүгийн гүйцэтгэлийг дэмжих нотлох баримт, худалдан авагчдын мэдээлэл, борлуулсан бүтээгдэхүүнийг хүргэх тээвэрлэлтийн байршил зэргийн мэдээллийн хүсэлтүүд багтсан байна.

90. Ноён Ли 1-р сарын 29-ний өдрийн Тушаалын хамрах хүрээнээс гадуурх асуудал байна гэсэн үндэслэлээр эдгээр зүйлтэй холбоотой мэдээлэл авах хүсэлтэд хариу өгөхөөс татгалзсан. ХТБ-д санхүүгийн тайлан өгөөгүй. ХТБ-ийн үзэж буйгаар Эрээн хотын бизнесийн эдийн засгийн үнэ цэнэ, улмаар PFL-ийн хувь хэмжээ нь уул уурхайн үйл ажиллагаа, хүдрийг уурхайгаас худалдан авагч руу шилжүүлэх галт тэрэгний хэрэгцээтэй холбоотой тул PFL-ийн хувьцааг үнэлэхэд чухал ач холбогдолтой, Тушаалын хамрах хүрээнд багтаж байсан.

91. ХТБ нь мөн ноён Лигийн PFL-ийн хувьцаанд нотолсон үнэ нь 138 сая ам.долларын [41] өмчийн үнэтэй ижил байж чадах уу гэдэгт эргэлздэг. Өмгөөлөгчийн зүгээс үл хөдлөх хөрөнгийн үнэ нь хувьцааны үнэ байж болохгүй бөгөөд ноён Ли PFL-ийн хувьцааны үнийн талаар ямар ч мэдэгдэл хийгээгүй гэж үзэж байна. Шилжүүлсэн зүйл бол Монголд тодорхой хэмжээний газар эзэмшдэг компанийн хувьцаа байсан. ХТБ нар хэлэхдээ, одоо хийгдэж байгаа мэдэгдлүүд нь өмнөх мэдэгдлүүдээс ялгаатай байна. Ноён Ли 2020 оны 1-р сарын 3-ны өдөр үйл ажиллагааныхаа мэдэгдлийг ирүүлсэн бөгөөд тэрээр бүх лавлагаагаа мэдээллээ гаргаж, Компанийн үйл ажиллагааны талаар бүрэн бөгөөд үнэн зөв мэдүүлэг өгөхөд шаардлагатай гэж үзсэн бүх бичиг баримтыг хянаж үзсэнээ нотолсон байдаг. Тэрээр компанийн бүх охин компаниудын санхүүгийн байдлын талаархи дэлгэрэнгүй мэдээллийг, тэр дундаа охин компани тус бүрийн шинэчилсэн тайлан балансыг баталгаажуулсан. Тэр PFL-ийн үнэ цэнийг 0[42] гэж өгсөн. Энэ бол цорын ганц удаа PFL-д бас хувьцаанд үнэлгээ өгсөн явдал юм.

[41] Гурав дахь Баталгаажуулах мэдэгдэл 2020 оны 1 дүгээр сарын 23, 6 хэсэг
[42] Баримт XL-3, 143-146х

Тухайн үед PFL-ийн хувьцааг SGL эзэмшдэг байсан. SGL-ийн санхүүгийн тайланд 2018 оны 12-р сарын 31-ний байдлаар 11,000.00 ам.долларын эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгө эзэмшиж байгааг харуулж байна. Тиймээс SGL нь PFL-ийн хувьцаанд томоохон үнэ цэнийг үзүүлээгүй. Өмгөөлөгч нь энэ хэргийн хүрээнд PFL-ийн хувьцаа маш бага үнэ цэнэтэй гэдгийг нотолж буй өөр нэг нотлох баримт юм.

92. ХТБ нь Хувьцааны үнэ ямар ч байсан Эрээний болон PFL-ийн түвшинд зээлдүүлэгчийн нэхэмжлэлд хамаарна гэсэн байр суурьтай байна. SGL-ийн эсрэг одоо байгаа нэхэмжлэл (энэ нь авагдсан тайлангийн санхүүгийн байдалд тусгагдаагүй) болон түүний хөрөнгийн доод түвшнийг харгалзан Өмгөөлөгч SGL-ийг төлбөрийн чадваргүй гэж үзэж, *"үнэ цэнэтэй эсэхээс үл хамааран хөрөнгө шилжүүлэх бизнес эрхэлдэггүй"* гэж мэдэгдэв.

93. Дүгнэж хэлэхэд, ХТБ-ийн нэрийн өмнөөс түүнийг төлөөлж буй Өмгөөлөгчийн гаргасан мэдэгдэл нь бусад бүх асуудлаас үл хамааран ноён Ли-ийн хувьцаанд өгсөн үнэлгээг үл харгалзан ХТБ-ууд хувьцаа нь ямар ч бодит үнэ цэнэгүй гэсэн дүгнэлтэд хүрсэн явдал юм. Ноён Ли Шүүхийг AP Appraisal Limited-ийн өгсөн үнэ цэнэд үндэслэх ёстой гэж уриалж байхад ХТБ-ийн нэрийн өмнөөс төлөөлж буй Өмгөөлөгч нь арилжааны асуудлаар ХТБ-ийн үзэл бодолд ихээхэн ач холбогдол өгдөг. Өмгөөлөгч нь ***DD Gross Premium 2 X Fund***-ийн[43] кейсд суурилсан бөгөөд ХТБ нар тухайн нөхцөл байдлын талаар мэдээлэлтэй байх хамгийн тохиромжит байр сууринд байна гэв.

94. ХТБ-ийн нэрийн өмнөөс төлөөлж буй өмгөөлөгч мөн ***In Re Exten Investment Fund et al***. кейсийг[44] дурдаж, үндэслэл болгов.
Энэ хэрэгт дөрвөн аж ахуйн нэгжийн хоёрынх нь талаар хүссэн үндсэн хөнгөлөлт тусламжийг хэсэгчлэн гаргасан ба дөрвөн аж ахуйн нэгжийн хоёрын хувьд хэсэгчлэн байсан ба сайн дурын үндсэн дээр татан буугдаж буй хоёр Сан тус бүр татан буугдсан өдрийг ***Компанийн тухай хуулийн*** (2016 оны шинэчилсэн найруулга) 151 (3) дүгээр зүйлд заасны дагуу хойшлуулна. Өргөдөл гаргагч нь Сангийн цорын ганц хөрөнгө оруулагч байсан. Тэрээр компанийг бие даасан, туршлагатай Албан ёсны татан буулгагчдаар шалгалт хийлгэх шаардлагатай, улмаар компанийн хэрэг бүрэн дуусаагүй байсан гэх үндэслэлээр компанийг татан буулгахыг хойшлуулахыг хүссэн. Сайн дурын Татан буулгагч нь хүсэлтийн тушаалуудыг эсэргүүцсэн байна.

---

[43] 2013 2 CILR 361
[44] FSD 96-99/207 шийдвэр 2017 оны 6 дугаар сарын 23

95. Өргөдөл гаргагч нь мэдүүлгээ бататгаж дэмжих үүднээс бараг нэг жилийн хугацаанд мэдээлэл авах хүсэлт тавьсан боловч заримд нь хариу өгөөгүй гэж мэдэгдэв. Тэрээр цаашлаад Швейцарь улсад Өргөдөл гаргагчийн шууд бус толгой компанитай холбоотой байж болзошгүй эрүүгийн мөрдөн байцаалтын ажиллагаа үргэлжилж байгаа бөгөөд Сангийн зүгээс эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцож буй аль нэг талын эсрэг нэхэмжлэл гаргасан эсэхийг шалгах шаардлагатай гэж мэдэгдэв. Өргөдөл гаргагч нь хүсэлт гаргаж байгаа захирамжаас бусад этгээдэд хохирол учруулахгүй гэж мэдэгдэв.

96. Дээд шүүх уг асуудлыг хэлэлцэхдээ Хонгконгийн шүүхийн хоёр шийдвэрийг зөвшөөрч, дараахь зүйлийг дурджээ.

> *30.* ***The Comission of Inland Revenue v Fullbright Co.Ltd, HCCW 208/2008*** *Хонгконгийн шийдвэрээс иш татсан. Заалт (17)-д Кван Жей энэ заалтын дагуу өөрийн үзэмжийг хэрэгжүүлэхэд баримтлах хандлагыг дараах байдлаар нэгтгэн дүгнэв.*
>
> > *"Шүүхээс компанийг татан буулгахыг хойшлуулах шийдвэрээ хэрэгжүүлэхийн тулд компанийн үйл ажиллагаанд ямар нэгэн дүгнэлт хийгээгүй, тухайлбал, олж илрүүлсэн эд хөрөнгө, зээлдүүлэгч болон татан буулгагчийн хооронд үл ойлголцол байгаа, татан буулгагчийн ажил дууссан эсэх талаар харуулах шаардлагатай. Өөрөөр хэлбэл, компани бол халхавч бүрхүүлээс өөр юу ч бус төдий ..."*
>
> *31.* ***Kelso Enterprises Limited, Liu Tiu Keung CACY 303/2006*** *хэргийн Хонг Конгийн давж заалдах шатны шүүхийн шийдвэрийн 13,15, 16, 20-р зүйлд Reogers VIP дараах хэрэгтэй зааврыг өгдөг:*
>
> > *13. Миний бодлоор 239(4) дэх хэсэгт заасны дагуу татан буулгах ажиллагааг хойшлуулах эсэх асуудалд зөв арга барил авч хэрэгжүүлэх нь татан буулгах ажиллагааг хойшлуулсанаар юунд суурилж, юунд хүрэх боломжтой вэ гэсэн асуултаас эхлэх ёстой. Тиймээс өргөдөл гаргагчийн тавьсан шалтгааныг эхлээд харгалзан авч үзэх хэрэгтэй. Энэ тал дээр мэдээж зээлдүүлэгчийн эрх ашиг маш чухалд тооцогдоно. Шүүх мөн нийтийн эрх ашгийг харгалзан үзэх ёстой. Тэрхүү нийтийн ашиг сонирхол гэдэгт татан буулгах үйл ажиллагааг зохистой, үр дүнтэй явуулах зэрэг багтана. Энэ нь эргээд компанийг үйл ажиллагааг явуулж буй этгээдүүдийн, компанийн үйл ажиллагаа явуулахад хариуцлага хүлээгч*

ИСПЕЛЬСКИЙ ПЕРЕВОДЧЕСКИЙ TRANSLATION BUREAU

этгээдүүдийн өмнөх үйл ажиллагаа, үйлдүүдийг шалгах хэрэгцээ шаардлага орно. Дараа нь Шүүх татан буулгах хугацааг хойшлуулсанаар аль нэг талд хохирол учруулах боломжтой эсэхийг авч үзэх ёстой.

...

15. Өргөдөл гаргагч нэхэмжлэлийн шаардлагыг санхүүжүүлсэн байх магадлал багатай гэсэн үндэслэлээр компанийн захирлуудад төлбөрийн чадваргүй байхад арилжаа хийх зөвшөөрөл олгосон тухай асуултыг Шүүгч хэрэгсэхгүй болгов. Компанийг төлбөрийн чадваргүй байхад мэдсээр байж арилжаа хийж байгаа захирлуудын ийм үйлдэлтэй холбоотой асуултууд нь иргэний нэхэмжлэлээс илүү ноцтой үр дагаварт хүргэж болзошгүй юм. Энэ мэт аливаа үйлдлийг сайтар шалгаж, шаардлагатай бол буруутай этгээдүүдээр хариуцлага хүлээлгэх нь олон нийтийн эрх ашигт нийцнэ.

...

16. Гуравдагч этгээд болон бусад зээлдүүлэгчид учирч болзошгүй хохирлын тухайд хэрэв буруутай үйлдэл гарсан бол буруутай этгээдүүд хариуцлага хүлээхээс өөр аргагүй гэж би харж байна. Үүнтэй холбогдуулан, шүүгч хэлсэн боловч үүнд ач холбогдол өгөөгүй нэгэн чухал асуудал бол өргөдөл гаргагч нь шүүх хуралдааны цаашдын үйл ажиллагааг санхүүжүүлэхэд бэлэн байсан явдал байв. Тиймээс зээлдүүлэгчид болон бусад оролцогчид ямар нэгэн байдлаар хор хөнөөл учруулахгүй байх нь чухал юм. Өргөдөл гаргагч их хэмжээний мөнгөө алдсан ч одоо байгаа хөрөнгөө эрсдэлд оруулахад бэлэн байгаа нь томоохон зээлдүүлэгч эргүүлэх шаардлагатай байгаа гэж үзэж буй лакмусын сорил гэдгийг нэмж хэлж болно.

...

20. Захиалга хийхдээ өргөдөл гаргагч өөрөө болон бусад зээлдүүлэгчийн нөхөн төлбөрийг баталгаажуулах баталгаа байхгүй гэдгийг хэлэх хэрэгтэй. Ямар нэгэн тодорхой буруу үйлдлийг шаардлагатай нотлох баримтын дагуу харуулах эсвэл хариуцлага хүлээсэн талуудад ямар нэгэн шийтгэл оногдуулж болзошгүй гэдэг нь тодорхой биш. Гэсэн хэдий ч зөвхөн нийтийн эрх ашгийн үүднээс ч гэсэн зохих ёсны мөрдөн шалгалт явуулах шаардлагатай асуудлууд байгаа нөхцөл байдал надад тодорхой санагдаж байна."

TRANSLATION BUREAU

97. Шүүх сүүлийн кейс тохиолдолд дээрх зааврыг ашиглаж, дараахь дүгнэлтийг гаргав.

a) *"Компанийн бизнесийн үйл ажиллагаа талуудыг сайн дураар татан буулгах ажиллагаа дуусахаас өмнө Өргөдөл гаргагчийн захидал харилцаанд дурдсан асуудлын талаархи мөрдөн шалгалт, мөрдөн шалгалтын ажиллагаа болон сэжигтэй төлбөртэй холбоотой нэхэмжлэлийн шаардлагыг биелүүлэхийг дуусгах шаардлагатай байгаа нь тодорхой байна.*

b) *Компаниуд татан буугдсан тохиолдолд тэдгээрт хамаарах сэжигтэй төлбөрийн талаар ямар нэгэн нөхөн төлбөр авах боломжгүй болно.*

c) *Компанийг удирдан явуулж буй этгээдүүдийн урьд өмнө гаргасан аливаа үйлдлийг зохих ёсоор шалгаж, шаардлагатай бол арга хэмжээ авах нь олон нийтийн ашиг сонирхолд нийцнэ".*[45]

98. Шүүх хойшлуулсан нь аль ч талд хохирол учруулахгүй гэж үзсэн. Өргөдөл гаргагч нь хохирол амссаны дараа шүүхийн хяналтад байгаа татан буулгах ажиллагааны зардлыг санхүүжүүлэхэд бэлэн байсныг шүүх мөн тэмдэглэж, мөрдөн шалгалтын ажиллагаа явуулах шаардлагатай чухал асуудлууд байна гэж үзэж байгаагийн илрэл гэж үзэв.

99. ХТБ-г төлөөлж буй өмгөөлөгч энэ хэрэг нь шууд бус хэдий ч тус нэмэртэй гэж үзэж байгаагаа илэрхийлж, Шүүхийг татан буулгах хугацааг хойшлуулсанаар ямар үр дүнд хүрнэ гэж найдаж буйг авч үзэхийг ХТБ урьж байгааг дамжуулав. 2019 оны 12-р сард өгсөн мэдээллийн талаар судалгаа хийсэн. Одоо ноён Ли нэмэлт баримт материал гаргаж өгнө гэсэн санал байхгүй. Түүнд ингэх хангалттай их хугацаа аль хэдийнэ байсан. ХТБ нь PFL-ийн хувьцаа нь ямар ч үнэ цэнэгүй гэсэн дүгнэлтэд хүрч, Компанийн бүрэн тарсан тул үргэлжлүүлэх нь ямар ч ашиггүй бөгөөд Шүүхээс компанийг татан буулгах шийдвэр гаргах нь зүйтэй гэж үзэв.

100. Ноён Лигийн нэрийн өмнөөс түүнийг төлөөлж буй өмгөөлөгч нь ***DD Growth Premium 2x Fund***-ийн кейст дурдсан тохиолдол нь тухайн хэрэгт хамааралгүй гэж мэдэгдэв. Өмгөөлөгч Татан буулгагчийн эрх мэдлийн хориг хязгаарлалтай холбоотой иш татсан хэргийг эсэргүүцэж няцаасан бөгөөд энэ нь Шүүхийн үзэмжийн асуудал юм. Тиймээс Татан буулгагчийн арилжааны

[45] 47 дугаар хэсэг

талаархи үзэл бодол нь эдгээр нөхцөл байдалд хамааралтай байх болно. Ингэхдээ:

> *"Шүүх татан буулгагчийн бүрэн эрхийг хязгаарлах эрхтэй байсан. Шүүх өөрийн үзэмжээр Компанийн тухай хуулийн 3 дугаар Хуваарийн 1-р Хэсэгт хамаарах эрх мэдлийг хязгаарлаж, хоирг тавихдаа санал болгож буй хэлцэл компанийн эрх ашгийг хангаж байсан эсэх зэрэг холбогдох бүх нотлох бариmтыг авч үзнэ. Гэвчхэрэв татан буулгагчид буулт хийх гэж оролдсон бол шүүхийн сонголт нь илүү сайн нөхцөл эсвэл өөр санал байгаа гэдэгт итгэлтэй биш л бол санал болгож буй хэлцэл хийх, эсвэл огт хэлцэл хийхгүй байх л сонголт байна. Татан буулгагч нь ихэвчлэн мэдээлэлтэй, бодитой үзэл бодлоо илэрхийлэх хамгийн тохиромжтой байр сууринд байсан бөгөөд эрх мэдлийг хязгаарлах, хориг тавих эсэх талаар хэлэлцэх уед энэ үзэл бодолд ихээхэн ач холбогдол өгөх байсан (үүнийг хийхгүй байх ноцтой шалтгаан байхгүй бол). Татан буулгах санхүүжилтийг олж авах өөр арга байгаагүй ба Татан буулгагчид зээлдүүлэгчдийн хорооноос баталсан өмгөөлөгчтэй шударгаар нөхцөл болзол бүхий төлбөрийн гэрээг тохиролцсон. Хэрэв хэрэг бүтэлгүйтсэн бол зээлдүүлэгчдийн байр сууриг хохироохгүй байсан. Иймд шүүх татан буулгагчид нөхцөлтэй, болзолт хураамжийн гэрээ байгуулах эрх мэдлээ ашигласан тохиолдолд хязгаарлалт тавьж болох байсан бөгөөд боломжтой (30-31-р зүйл; 50-р зүйл).*

101. Ноён Лигийн нэрийн өмнөөс төлөөлж буй өмгөөлөгч нь үнэ цэнэ бүхий эд хөрөнгө байгаа нь тодорхой бөгөөд шүүх нь хүссэн татан буулгах шийдвэрийг гаргах шүүхийн харьяалалгүй гэж маргажээ. Маргаан бүхий хөрөнгийн үнэлгээний талаархи ХТБ-ийн мэдээлэл байхгүй байгаа тул Шүүхэд өргөдлийг хангах бодит үндэслэл өгөгдөөгүй гэж үзэж байна.

102. Өмгөөлөгчийн мэдүүлэгт ХТБ нарын ашигласан нэр томъёо нь үнэ цэнэ байхгүй гэсэн эерэг үзүүлэлт гэхээсээ илүү "*үнэ тогтоох*" боломжгүй гэсэн нотолгоо нь өөрсдөдөө зориулсан үнэлгээнд хүрэхийн тулд шаардлагатай ажлыг хийгээгүйн тод илрэл гэж мэдэгдэв. Тэд ноён Лигийн нэрийн өмнөөс өгсөн үнэлгээнд итгэдэггүй атлаа өөрсдөө альтернатив буюу сонголт хийж болохуйц үнэлгээ гаргаж өгөөгүй байдаг. Тэр ХТБ-н арга барилыг олон янзын үнэлгээний аргуудыг төөрөгдүүлсэн гэж шүүмжилсэн. Үйл ажиллагааны санхүүгийн тайлан нь зах зээлийн бодит үнэ цэнэ биш нягтлан бодох бүртгэлийн үнэлгээ юм гэж тэр хэллээ. Гэсэн хэдий ч ХТБ-ийн үнэлгээний тооцоолол хамгийн доод

ИСПЕРА ХХК
TRANSLATION BUREAU
/ОРЧУУЛГЫН ТӨВИЙН/
АМС00416 ☎ 5616

түвшинд байсан ч хөрөнгийн үнэ цэнэ болох 24 сая ам. доллар нь ихээхэн үнэ цэнэтэй дүн юм. Өмгөөлөгч Эрээний газар нь бүрэн үнэ цэнэгүй болсон гэж хэлж болохгүй гэв. Өмгөөлөгч ноён Лигийн боловсруулсан уг эд хөрөнгө дээрх төмөр зам, терминалын зураг бүхий баримт материалыг онцолж, уурхайд юу тохиолдсон талаар мэдээлэл байхгүй ч үнэ цэнэгүй гэсэн бодит нотолгоо мөн байхгүй гэж мэдэгдэв. Тэрээр ХТБ нар өөрсдийн үнэлгээг өгөхгүй байгаа шалтгаанд эргэлзэж, Санхүүжилтийн асуудал байгаа тул зөвлөгөө авах болон бусад арга хэмжээг авах боломжгүй бол ХТБ-ийн байр суурийг ойлгож болох боловч зээлдүүлэгчид эдгээр асуудлыг судлахад санхүүжилт олгохгүй гэсэн нотлох баримт байхгүй байна гэв.

ЗЭЭЛДҮҮЛЭГЧДИЙН ӨМНӨӨС ХИЙСЭН МЭДЭГДЛҮҮД

103. Сонсгол шүүх хуралдаанд гурван зээлдүүлэгчийн хоёрыг төлөөлж өмгөөлөгч оролцов. Компани 150 сая ам.долларын өртэй байгаа CDB-ны нэрийн өмнөөс төлөөлж буй Өмгөөлөгч нь ХТБ-ын хүсэлтийг дэмжиж буйгаа илэрхийлэв. Зээлдүүлэгчид энэ үйл явцад оролцоогүй, бичиг баримт бүрдүүлж гаргаж өгөх боломж байгаагүй мэт сэтгэгдэл төрүүлсэн ноён Лигийн нэрийн өмнөөс төлөөлж буй өмгөөлөгчийн мэдүүлсэнийг буруу гэж тэр хэлэв.

104. ХТБ-с Зээлдүүлэгчдэд баримт бичгийг өгсөн, мөн бичиг баримт гаргаж өгөх боломжтой байсан гэж тэрээр тодруулав. Тэрээр идэвхитэй үүрэг хүлээсэн ноён Лигээс нь ялгаатай нь зээлдүүлэгчийн хувьд бичиг баримт гаргаж өгөх үүрэг хүлээгээгүй гэж мэдэгдэв.

105. Өмгөөлөгч нь түүний үйлчлүүлэгчид бүрдүүлсэн бичиг баримтыг бүрдүүлж өгсөн, зардлын үр ашгийн дүн шинжилгээ хийх боломжтой байсан бөгөөд ийм нөхцөлд санхүүжилт олгохгүй байхаар шийдсэн гэв.

106. Байлцсан хоёр дахь зээлдүүлэгчийн өмгөөлөгч нь түүний оролцож буй байдал нь зөвхөн оролцох төдий, ямар ч эсэргүүцэл үзүүлэхгүй байхаар хязгаарлагдаж байгааг илэрхийлэв.

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ, ДҮГНЭЛТ

107. Хувьцааг шилжүүлсэн нь хүчин төгөлдөр эсэх талаар маргаан их байсан бөгөөд ХТБ үүнийг хүчингүй гэж үзсэн. Ноён Лигийн нэрийн өмнөөс төлөөлж буй Өмгөөлөгчийн зүгээс хууль ёсны эзэмших эрхийн талаар өргөн хэмжээнд

хөндсөн аргументууд бий. Гэсэн хэдий ч Гишүүдийн Бүртгэлд тусгагдсан Хувьцааны эзэмших эрх болон шилжүүлгийн гүйцэтгэлийн албан ёсны байдлаас гадна илүү чухал асуулт бол шилжүүлэгт нөлөөлөхүйц зээлдүүлэгчийн хориг хязгаарлалт байгаа эсэх, PFL-ийн Хувьцааны үнэлгээнд нөлөөлж байгаа эсэхээс илүү чухал асуудал гэж би үзэж байна. Түүний үнэ цэнэ нь охин компанийн эзэмшиж буй Хөрөнгийн үнэлгээтэй салшгүй холбоотой гэж маргаж байна. Тиймээс би үнэлгээ, санхүүжилттэй холбоотой бүх нотлох баримт, мэдүүлгийг анхааралтай авч үзсэн.

108. Энэхүү Гурав дахь баталгаагаар ноён Ли 2014 оны 12-р сарын 31-ний өдрийг дүүсталхи хугацааны PFL-ийн аудитаар орсон санхүүгийн тайланг гаргасан. PFL нь 12,272,020.00 хонконг долларын цэвэр алдагдал бүртгэж, 21,592,176.00 хонконг долларын[46] цэвэр өр төлбөртэй байсан. 2015 оны 12-р сарын 31-нд дуусгавар болсон жилийн хугацаанд компанийн богино хугацаат өр төлбөр нийт хөрөнгөөс 39,379,384.00 хонконг доллароор давсан байна. Энэ нөхцөл байдал нь компанийн үйл ажиллагааг үргэлжлүүлэх чадварт ихээхэн эргэлзээ төрүүлж болзошгүй тодорхой бус байдал байгааг харуулж байна гэж Аудиторууд мэдэгдэв[47]. 2018 онд 11,843,197.00 хонконг долларын цэвэр алдагдал хүлээсэн бөгөөд богино хугацаат өр төлбөр нь нийт хөрөнгөөсөө 60,995.298.00 хонконг доллароор[48] давсан байна. Аудиторууд санхүүгийн тайлангуудыг үйл ажиллагаагаа тасралтгүй явуулж буй зарчмаар бэлтгэсэн болохыг холбогдох компаниас баталгаажуулсанаар тухайн компанийг тогтвортой үйл ажиллагаа явуулахад шаардлагатай санхүүгийн туслалцаа үзүүлнэ гэж бүртгэсэн. PFL-ийн 2019 оны 12-р сарын 16-ны өдрийн санхүүгийн байдлын тайлангаар түүний богино хугацаат өр төлбөр нь хөрөнгөнөөсөө 219,287,656.00 хонконг доллароор давж, хуримтлагдсан алдагдал 60,833,657.00 хонгконг доллар[49] болсон байна.

109. SGL-ийн санхүүгийн байдлын хувьд 2014-2018 онуудад ноён Лигийн гаргаж өгсөн SGL-ийн дансны дагуу цэвэр хөрөнгийг 10,000.00 ам.долларааар бүртгэсэн байв. PFL-ийн дансанд SGL нь түүний шууд бөгөөд эцсийн холдинг компани гэж тодорхойлсон байдаг ч эдгээр бүртгэлд PFL-ийн үнэ цэнийг харуулаагүй болно.

110. Шүүх PFL санхүүгийн хувьд эрүүл бус байдалтай байгаа тухай тодорхой ойлголттой үлдсэн. Шилжүүлгийг гүйцэтгэх гэж байсан SGL бүр илүү дород

[46] Х 25 – Баримт XL-3, ноён Лигийн Гурав дахь удаагийн Баталгаажуулах мэдэгдэл
[47] Х 43 – Баримт XL-3, ноён Лигийн Гурав дахь удаагийн Баталгаажуулах мэдэгдэл
[48] Х 112 – Баримт XL-3, ноён Лигийн Гурав дахь удаагийн Баталгаажуулах мэдэгдэл
[49] Х 157 – Баримт XL-3, ноён Лигийн Гурав дахь удаагийн Баталгаажуулах мэдэгдэл

байдалтай байсан. Баримт бичгүүдийн нүүрэн хэсгээс нь харахад компанийн аль нь ч өөрийн хүслээр хөрөнгө шилжүүлэх боломжгүй байгаа нь ХТБ нарын үнэн зөв байна.

111. 2020 оны 1-р сарын 29-ний өдрийн Тушаалын дагуу ХТБ нарын мэдээлэл авах хүсэлтийн 11-р Зүйлд ноён Ли-д PFL-ийн хувьцааны өөрийн хөрөнгийн үнэлгээг өгөх эсвэл үнэлгээг ХТБ-р хийж гүйцэтгүүлэх сонголтыг өгсөн. Үүнд дараахь мэдэгдлийг багтаасан болно.

> *"Энэхүү хүсэлт нь хэрэв даалгасан ажил нь хийж гүйцэтгэгдсэн бол ХТБ нь Эрээний өмч бус, харин PFL-ийн хувьцааг эзэмших болно, тиймээс Пийс Феймийн хувьцаанаас ямар үнэ цэнийг гаргах боломжтой болохыг мэдэх шаардлагатай байгааг харуулж байна."*

112. Ноён Ли үнэлгээг ХТБ-аар бус өөрийнхөө зааврааар хийлгэхээр сонгосон. Одоо харин ХТБ нарыг өөрсдийнхөө ажлыг хийсэнгүй гэж гомдоллож байна, гэтэл ХТБ нар Үнэлгээчин-ээс ярилцлага авахыг хүссэн бөгөөд өөр асуултуудыг бичгээр өгсөн байсан. Дээр дурдсанчлан хариу өгсөн гэх Үнэлгээчин нь аль ч хувилбарыг хүлээн аваагүй байна.

113. Энэ нь ноён Лигийн өөрийнх нь хийсэн алдаа байсан бөгөөд тэрээр одоо ХТБ нарыг зөвхөн шүүх шинжилгээний ажиллагаа хийсэн, өөрсдийн үнэлгээг хийж гүйцэтгээгүй гэж буруутгахыг оролдож байна хэмээсэн ХТБ нарын нэрийн өмнөөс төлөөлж буй Өмгөөлөгчийн мэдүүлгийг хүлээн авахгүй байх хэцүү юм.

114. 2015 оны 1-р сарын 1-нээс хойш БНХАУ-ын эрх баригчдад PFL-ийн хувьцааны үнэлгээ болон Эрээний бүх мэдүүлэгтэй холбоотой хүсэлтээс гадна ХТБ нар Эрээний өнөөгийн байдлын талаархи дэлгэрэнгүй мэдээлэл авч, 17 дэд асуултуудыг тавьсан.

115. Ноён Ли өөрийн Тав дахь Баталгаажуулсан мэдэгдэлдээ мэдээлэл авах хүсэлтийн заримд нь хариу өгөөгүй гэдгээ тайлбарлахыг хүссэн. Ингэхдээ Тушаал нь түүнээс асуусан зарим асуултыг SGL-ээс Компанид шилжүүлсэн гэх асуудалтай холбоотой байсан буюу Компанийн Монгол дахь уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой буюу бүхэлдээ өөр тусдаа асуудлыг хөндсөн байх бөгөөд энэ нь Тушаалын хүрээнээс гадуур байсан гэв

116. Тэрээр цааш нь үргэлжлүүлэн, Эрээний төмөр замын үйлчилгээний үйл

ажиллагаатай холбоотой хэд хэдэн асуултад барилга байгууламж нь хараахан ашиглалтад ороогүй байгаа тул хариулт өгөх боломжгүй байсан гэв. Тэрээр Эрээний бизнес эрхлэх зөвшөөрлийг боловсруулан гаргаж өгсөн бөгөөд өөрийгөө Компанийн Хууль ёсны Төлөөлөгч бөгөөд ТУЗ-д үлдсэн цорын ганц захирал төдийгүй Даргаар нь ажиллаж байгаа тухайгаа мэдэгдэв. Тэрээр Эрээний байгууламжийн сүүлийн үеийн гэрэл зургуудыг гаргаж үзүүлэн, дараах зүйлийг хэлэв:

> *"Эдгээр барилга байгууламжууд нь хэдий ашиглалтад ороогүй байгаа ч үйлдвэрийн дэд бүтэц, төмөр зам, депогийн барилгын ажил дуусч, тоног төхөөрөмжийн 85 орчим хувийг худалдан авсан. Үлдсэн тоног төхөөрөмжийн нийлүүлэлт, тоног төхөөрөмжийн суурилуулалтыг дуустал, мөн COVID-19-ийн нөхцөл байдлын улмаас цаашид үүсэх, гарах тасалдал бий болох зэргээс харахад Эрээний байгууламжууд 2020 оны 9-р сард ашиглалтад орох төлөвтэй байна.*
> *Эрээний барилга байгууламжийг ашиглалтад оруулахад 30-40 сая юань ("Хөрөнгө оруулалтын сан" гэх) шаардлагатай гэж би тооцоолж байгаа.*
> *Хөрөнгө оруулалтын Санг өрийн санхүүжилтээр бүрдүүлэхээр зорьж байгаа. Ийм санхүүжилт хараахан гараагүй байна.*
> *Одоогоор бизнес төлөвлөгөө байхгүй байна. Эрээний Аж ахуйн нэгж COVID 19-ийн нөлөөллийг үнэлнэ..."*

117. ХТБ нар мэдээлэл авах хүсэлтээ хэвээр үлдээсэн бөгөөд 2020 оны 4-р сарын 14-нд ноён Лигээс мэдээлэл авах хүсэлтээ дахин тавьсан боловч хариу ирүүлээгүй байна.[50]

118. Мэдээлэл хүссэн тухайд ХТБ нарын байр суурь үндэслэлтэй байна. Асуултууд нь Хувьцаа болон Хөрөнгийн боломжит үнэ цэнийн талаарх зургийг олж мэдэхэд зориулагдсан бололтой. Ноён Ли хариу өгөхгүй байхыг сонгосон нь харамсалтай. Түүний компанид янз бүрийн албан тушаал хашиж байснаас үзэхэд, мөн цорын ганц захирлын хувьд энэ мэдээллийг олж өгөхөд хамгийн боломжит байр сууринд байсан юм. ХТБ нарын Өмгөөлөгч түүний хариултыг саад тотгор учруулж болзошгүй гэж баттай тайлбарласан ч, энэ нь ядаж түүний өөрийнх нь хувьд ашиггүй байсан юм. Ноён Ли өгөхөөс татгалзсан учир ХТБ нар мэдээллийн өөр ямар арга замыг эрэлхийлэх нь тодорхойгүй байна.

[50] Баримт РС-4, 99х

119. Ноён Коулейгийн Дөрөв дэх мэдүүлэгт үнэлгээний асуудлыг нарийвчлан авч үзсэн байдаг. Тэрээр хэлэхдээ:

> *"Хэдийгээр ХТБ нар Хувьцааны шилжүүлэг хийгдээгүй гэж үзсэн ч Компанийн хөрөнгийг цуглуулах, бодит үнэ цэнийг нь гаргах үүргээ харгалзан бид Компанид хувьцаа авахыг оролдох нь Компанийн зээлдүүлэгчид ямар нэгэн ашиг тустай эсэхийг авч үзэх ёстойгоо хүлээн зөвшөөрч байна. Үүнтэй холбогдуулан ХТБ нар Хүсэлтийн 4-15 дугаар зүйлд хариуд өгсөн баримт бичиг, мэдээллийг хянаж үзээд дараах зүйлийг тэмдэглэв."*[51]

120. Ноён Коулейгийн өгүүлсэнээр Хувьцааны үнэлгээг хийхдээ ХТБ нь хувьцааны үндсэн үнэ цэнийн хамт Хувьцааг хэрэгжүүлэх эрсдэл, зардлыг харгалзан үзсэн. Тухайлбал, SGL-ийн санхүүгийн байдал, 2015 оны Төлбөрийн Гэрээний нэмэлт өөрчлөлт, үр нөлөө, Хувьцааг үнэлэх, Эрээний одоогийн үйл ажиллагааны байдал, PFL-ийн 100 хувь эзэмшдэг үндсэн бизнес зэрэг эрсдэл, зардлын сэдвийн дор авч үзсэн асуудлуудыг хөндсөн.

121. Хөрөнгө шилжүүлсэнээр SGL-д CDB-д төлөх ёстой хэмжээнээс бага хэмжээний хөрөнгө үлдэх болно гэдгийг ХТБ нар ажиглаж байгаа ба ХТБ нар ноён Ли-ээс Хувьцааг Компанид шилжүүлэхэд CDB татгалзсан явдал бий эсэхийг асуусан. Үүний хариуд тэдэнд Банк тэгэхгүй тэгэхгүй гэж зөвлөсөн. Иймээс шилжүүлэг нь маргаантай байж болох томоохон эрсдэл байна гэж гарцаагүй дүгнэлтэд хүрлээ.

122. Ноён Коулей цааш нь үргэлжүүлэн хэлэхдээ, ХТБ нар шилжүүлэг нь SGL-ийн захирлуудын үүрэг хариуцлагыг зөрчсөн байж болох томоохон эрсдэлтэй байгааг тэмдэглэв. Түүнчлэн, Шүүхийн ажилтны хувьд тэд итгэлцлийн үүргээ зөрчсөний улмаас хөрөнгөө мэдсээр байж хүлээн авах боломжгүй бөгөөд ийм зөрчлийг арилгахад туслах боломжгүй юм. Хувьцааг зөрчилгүй шилжүүлсэн ч дээр дурдсан эхний эрсдэл хэвээр үлдэнэ гэж тэд дүгнэж байна.

123. Төлбөрийн Гэрээний тухайд 2.8-д заасны үр нөлөөг тодруулах, тухайлбал, SGL-д PFL-ийн хувьцааг шилжүүлэхийн тулд CDB-ын зөвшөөрөл шаардлагатай эсэхийг тодруулах зорилгоор ХТБ хуулийн дүгнэлт гаргуулсан. 2015 оны 6-р сарын 18-ны өдрийн CDB, Компани, ноён Ли, SGL болон бусад талуудын

[51] Дөрөв дэх удаагийн Мэдүүлэг 202 оны 5 дугаар сарын 13, 29 хэсэг

TRANSLATION BUREAU
ОРЧУУЛГЫН ТОВЧОО
АМС00416 5616395
УЛААНБААТАР ХОТ

хооронд байгуулсан Төлбөрийн Гэрээний 2.8 (е)-д CDB-ийн бичгээр өгсөн зөвшөөрлийг авалгүйгээр Ланг Мингийн талуудын аль нь ч SGL-ийн хувьцаа эзэмшлийн бүтцэд өөрчлөлт оруулах, эсвэл өөрийн охин компаниуд дахь эзэмшлийн хувийг бууруулахыг хориглоно гэж заасан. Гарын үсэг зурсан зөвшөөрөл олгосон нотлох баримт байхгүй.

124. Санал дүгнэлт нь дараахь тохиолдлуудад хэрэглэгдэнэ гэж таамаглаж байна:

i. SGL-ийн зээлдүүлэгчид хувьцаагаа шилжүүлэх аливаа оролдлогыг эсэргүүцэх эрсдэлтэй.

ii. Ноён Лигийн үндэслэсэн Төлбөрийн Гэрээ болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн үр нөлөө нь CDB-ын зөвшөөрөлгүйгээр Хувьцааг буцаан шилжүүлэхээс урьдчилан сэргийлэх явдал байсан бөгөөд үүнийг CDB эсэргүүцэх эрхгүй болно.

125. Хүлээн авсан саналуудаас БНХАУ-ын өмгөөлөгчдийн зүгээс SGL компанид хувьцаагаа шилжүүлэхийн тулд CDB-ын зөвшөөрөл шаардлагатай эсэхийг авч үзээгүй тул хамрах хүрээ хэт явцуу байна гэж ХТБ үзжээ. Энэ нь Төлбөрийн Гэрээнд тусгагдсан Хувьцаа буцаах нь PFL-ийн хувьцааг бус SGL болон Айро Майнинг Интернэшнл (Монголиа) Лимитед компанийн хувьцааг Компанид буцаан шилжүүлэх явдал байсан. ХТБ-ийн үзэж буйгаар БНХАУ-ын дүгнэлт нь SGL нь CDB-д өртэй, төлбөрийн чадваргүй мэт харагдаж байгаа тул баталгаа болохгүй байна.

126. Хувьцааны үнэлгээний хувьд ХТБ нар нь АР Appraisal-аас өгсөн үнэлгээ нь хөрөнгийн дахин үйлдвэрлэх эсвэл солих зардалд илүү төвлөрч, 106 сая ам.долларын үнэлгээг хэрхэн хэрэгжүүлэх талаар ойлгоход тус болохгүй болохыг тэмдэглэж байна. Үнэлгээчин нь хөрөнгийн хуучирч болзошгүй нөлөөллийг харгалзан үзсэн үзүүлэлтийг ч мөн авч үзээгүй байхад үүнийг ХТБ чухал зүйл гэж үздэг. Үүнээс гадна, Үнэлгээчний хэлсэн болон ноён Лигийн өгсөн өр төлбөрийн хүснэгтэд заасан өр төлбөрийн тоонуудын зөрүүгээс гадна үнэлгээ нь PFL-ийн бизнесийн эцсийн эзэмшигч нь дэмжиж, бизнест хүүгүй санхүүжилт олгоно гэж тооцсон болно. Ялангуяа төлбөрийн чадваргүй Компанид Хувьцаа шилжсэн тохиолдолд Компани барилгын ажлыг дуусгахад шаардагдах хөрөнгийг зээлэх боломжгүй болж байгаа нь үндэслэлтэй таамаглал биш хэмээн ХТБ нар тайлбарлав.

127. Үнэлгээчин Хятадын Эрх бүхий байгууллагуудад 2018 оны эцэс гэхэд

Эрээн 20 сая ам.долларын цэвэр хөрөнгөтэй болсон гэж мэдүүлсэн мөртлөө 106 сая ам. доллар гэж үнэлж байгаа нь үнэлгээнд илэрхий гажуудал бий гэдгийг ХТБ нар мөн онцолж байна. 2020 оны 1-р сарын 3-ны өдөр ноён Ли өөрийн мэдэгдэлдээ PFL-г тэг, Эрээнийг 20 сая доллараар үнэлэв. ХТБ нар үнэлгээнд ийм их өөрчлөлт байж болох эсэх талаар асууж лавлаж байгаад гайхах зүйл үгүй.

128. Ноён Ли Эрээний бизнесийн үйл ажиллагааны барилга байгууламжийг барьж дуусгахын тулд Эрээний бизнесийн үйл ажиллагааг өрийн санхүүжилтээр 4-5.5 сая ам.доллараар нэмэгдүүлэх шаардлагатай байгааг дурдаад, санхүүжүүлэгч олдоогүй байгаа бөгөөд мөн үйл ажиллагаагаа эхлүүлэхэд ихээхэн хэмжээний нэмэлт эргэлтийн хөрөнгө шаардлагатай болохыг ХТБ онцлон тэмдэглэж байна.

129. ХТБ-ийн тодорхойлсон эрсдэл, зардалд дараахь зүйлс орно.

i. Хөрөнгөд аль хэдийнэ хуучирсан эрсдэл.
ii. CDB –ийн сөрөлттэй холбоотой гарах эрсдэл/зардал.
iii. Барилга угсралтын ажлыг дуусгах, үндсэн бизнесийг явуулах санхүүжилт авахтай холбоотой эрсдэл/зардал.
iv. Монгол Улсын алслагдсан байршилд байгаа хөрөнгө борлуулахтай холбоотой эрсдэл/зардал.
v. Эдгээртэй холбоотой ХТБ нарын өртөг ба зардал (санхүүжилтийн аливаа зардлыг оруулаад).

130. Эдгээр бүх асуудлыг харгалзан үзсэний үндсэн дээр ХТБ нарын гаргаж буй дүгнэлт нь ноён Лигийн өгсөн мэдээллийн дагуу Хувьцаанд бодит үнэ цэнийг тогтоох боломжгүй.

131. Санхүүгийн тайлан, Компанийн тухай мэдээлэл, бусад аж ахуйн нэгжүүд, PFL SGL болон тэдгээрийн төлбөрийн чадваргүй байдлын янз бүрийн нөхцөл байдал, тэдгээрийн эсрэг зээлдүүлэгчийн нэхэмжлэлүүд, зээлдүүлэгчийн болзошгүй хориг хязгаарлалт зэргийг хянан үзээд, маргаантай хөрөнгөөс ямар нэг үнэ цэнийг олж гаргахыг эрэлхийлэх нь туйлын найдваргүй ажил болж байгаа бөгөөд муу мөнгөний араас сайн мөнгө зарцуулагдаж, маргаантай хөрөнгө үзэгдэж харагдаж байснаа улам уусан алга болох явдал улам ойртож буйг Шүүх харж байна.

132. Хоёрдугаарт, ноён Лигийн өмгөөлөгч хориг хязгаарлалтын мэдүүлэг

болон бусад үзэмжийн асуудлын хоорондын ялгааг сайн тодорхойлсон боловч Шүүх ийм нөхцөл байдалд үнэ цэнэ ба эрсдлийг тооцон үзэж, ХТБ нарын туршлага, мэдлэгийг анхаарч авч үзэх хэрэгтэй гэж байр сууриа илэрхийлэв. Ноён Коулейгийн Дөрөв дэх мэдэгдлийн 35-р догол мөрийг уншиж байхдаа үнэ цэнийг бодит үнэ цэнийг хэрэгжүүлэхэд учирч болзошгүй зардал, эрсдэлтэй харьцуулж үзэхэд үлдэгдэл нь тухайн эрсдэлийг хүлээх хэмжээний биш байна.

133. ХТБ өөр боломжит хөрөнгө байгаа эсэхийг мөн авч үзсэн. Компани 2013 он хавьцаа ойролцоогоор 54 сая ам.долларын зээлийг PFL-д өгсөнийг хянан үзсэн. Эрээн энэ зээлийг одоо болон ирээдүйд төлөх боломжтой гэдгийг нотлох баримт илрээгүй нөхцөлд эргэн төлөлт нь PFL-ийн төлбөрийн чадвараас л хамаарна. Ийм зээлийн гүйцэтгэл, түүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлууд болон ноён Лигийн 2019 оны 12-р сарын 8-ны өдөр Компанийн эзэмшилд томоохон өмч хөрөнгө байхгүй гэж баталгаажуулах мэдэгдлээс ХТБ нар үзээд, энэ зээлийн бодит үнэ цэнийг тэд тооцох боломжгүй гэсэн дүгнэлтэд хүрэв.

134. SGL болон IMIML-ийн хувьцаатай холбоотой 2015 оны Төлбөрийн Гэрээний дагуу Компанид хувьцаагаа эргүүлэн авах эрх боломжтой болохтой холбогдуулан ХТБ ийнхүү өгүүлэв:

> *"CDB-ийн өмнө хүлээх 166 сая ам.долларын өрийн хариуцлага, мөн дээр дурдсан төлбөрийн чадваргүй байдал зэрэг нь "Шайни Глоу" компанийн хувьцааг үнэ цэнэгүйг харуулж байна (Пийс Фейм нэрийн хувьцааг 106 сая доллараар үнэлэгдэж байсан ч)."*[52]

135. Компанийн Айрон Майнинг Интернэшнл Лимитед ("IMIML") дахь эрхийн талаар мөн шалгалт хийсэн. Ноён Ли Компани нь тус компанитай ямар ч ашиг сонирхлын асуудалгүй гэж зөвлөв. Түүгээр ч зогсохгүй Төлбөрийн Гэрээний дагуу IMIML-ийг 166 сая ам.долларын өр төлбөрийн хариуцлагын хувьд SGL-тэй хамтран хариуцагч болохыг шаардаж байгааг ХТБ өгүүлэв. IMIML-ийн хувьцаа нь Компанид үнэ цэнэтэй байх болно гэсэн ямар ч баталгаа байхгүй.

136. ХТБ нарын гаргасан дүгнэлтээр эдгээр бүх асуудлыг харгалзан үзсэний үндсэнд тэд SGL эсвэл IMIML-ийн хувьцаанд бодит үнэлгээ тогтоох боломжгүй байна.

137. Өгөгдсөн бүх материалыг авч үзсэний үндсэн дээр Компани нь үнэ

[52] 41 хэсэг с , Патрик Коулейгийн Дөрөв дэх удаагийн Мэдүүлэг

цэнэтэй хөрөнгө, тухайлбал PFL-ийн хувьцаатай гэсэн нь нотлогдоогүй гэж би үзэж байна. Практикийн хувьд батлагдсан үнэ цэнэ эсвэл аливаа үнэ цэнэ нь огт байхгүй эсвэл хэрэгжих боломжгүй байдаг. Үүнийг хэрэгжүүлэх аливаа оролдлого алхам тутамдаа эрсдэл, сорилтоор дагуулах нь бий. Компани руу шилжүүлэх нь эргэлзээтэй байна. Компани нь Хувьцаанд тэгш эрх эзэмшдэгийг нотлох нь тун эргэлзээтэй. PFL нь Төлбөрийн Гэрээний нэг тал байсан эсэх нь өнгөн талаас харахад эргэлзээтэй, Компани илүү давуу эрх нэхэмжилсэн бол SGL-ийн сөрөлтийг үр дүнтэй даван туулж чадах эсэх нь эргэлзээтэй байна. Эцсийн эцэст энэ бүхнийг даван туулж чадах байсан ч хүрэх цэг нь юу гэдэг нь асуултын тэмдэг. Эрээний үнэлгээ нь зээлдүүлэгчийн нэхэмжлэл болон бусад хүчин зүйлийг харгалзаагүйн улмаас эргэлзээтэй байсан. Хэдийгээр SGL нь PFL-ийн эзэмшлээр дамжуулан Эрээний 24 сая ам.долларын үлдэгдэл хөрөнгөтэй үлдсэн ч санхүүгийн тайлангуудаас харвал SGL төлбөрийн чадваргүй, PFL өөрөө өртэй байна. Компани нь төлбөрийн чадваргүй тул хөрөнгө зээлэх боломжгүй.

138. Энэ хөрөнгөнд бодитой болон бодитойгоор хэрэгжих ямар ч үнэ цэнийг тогтоох боломжгүй гэсэн ХТБ нарын үнэлгээг зөв гэж би дүгнэж байна. Өөрөөр хэлбэл, миний харсан бүх нотлох баримтаас харахад ямар нэгэн үнэ цэнийг хэрэгжүүлэх бодит хэтийн төлөв харагдахгүй байна.

139. Би зээлдүүлэгчдийн байр суурийг мөн харгалзаж үзсэн. Нийтлэг зээлдүүлэгч нь энэхүү маргаантай хөрөнгийн араас хөөцөлдөөгүй. Хэдий тодорхой бус ч, гурван зээлдүүлэгчийн хэн нь ч 24 сая ам.долларын өрийн дараа санал болгож буй үлдэгдэл үнэ цэнийг үл харгалзан энэ хөрөнгийг хөөцөлдөн авахыг хүсээгүйг дурдах нь зүйтэй. Шүүх зээлдүүлэгчдийн үзэл бодлыг зохих ёсоор анхаарч үздэг.

140. Санхүүжилтийн хувьд бодитой анхаарч үзвэл зохих зүйл бас бий. 2019 оны 12-р сарын ХТБ нарын Эцсийн Тайланд Татан буулгах Хорооны анхны хурлаар 2015 оны бүтцийн өөрчлөлтийг буцаах үүднээс авч болох алхмуудыг хэлэлцсэн гэж тэмдэглэжээ. Санхүүжилтийн хүрээнд татан буулгах үйл ажиллагааг санхүүжүүлэх бэлэн мөнгө байхгүй байгаа бөгөөд өнөөдрийг хүртэл татан буулгах бүх зардлыг шийдвэрлэхэд шаардагдах санхүүжилтийн талаар ХТБ нар нь өргөдөл гаргагч зээлдүүлэгчтэй ярилцсан хэвээр байгааг тэмдэглэв.

141. Нэгдүгээр сард болсон сонсгол хурлын үеэр Татан буулгагчдыг төлөөлөн Өмгөөлөгч цаашдын хэрэг бүртгэлийн ажиллагааг санхүүжүүлэх ямар ч

санхүүжилт байхгүй тул ноён Ли үүнийг хийх үүрэг хүлээсэн гэдгийг тодорхой хэлсэн.

142. 2020 оны 5-р сард гаргасан ХТБ нарын хамгийн сүүлийн Мэдүүлэгт татан буулгах үйл явцад гарсан янз бүрийн үйл явдлын талаар зээлдүүлэгчид бүгдэд нь мэдэгдсэн бөгөөд уг асуудал тараах, татан буулгах өргөдлийн шатанд шилжиж байгаа талаар мэдэгдсэн.

143. Хатагтай Каруанагийн мэдүүлгийн ELC 1-д баримтад үзүүлсэнээр Компанийн гурван зээлдүүлэгч маргаантай хөрөнгийг шилжүүлсэн гэх цаашдын мөрдөн шалгалтын ажиллагааг санхүүжүүлэх хүсэлгүй байсан бөгөөд Компанийг татан буулгахад сэтгэл хангалуун байсан гэсэн ойлголтыг Өмгөөлөгчийн зүгээс ХТБ-д өгсөн.

144. Энэхүү шүүх хуралдаанд Өргөдөл гаргагч зээлдүүлэгчийн нэрийн өмнөөс түүнийг төлөөлж буй Өмгөөлөгч үр дүнтэй эсэх нь эргэлзээтэй гэж үзэж буй нэмэлт ажиллагаанд санхүүжилт олгохгүй гэдгээ тодорхой бөгөөд хоёрдмол утгагүй илэрхийлэв. Энэхүү маргаантай эд хөрөнгөө хөөцөлдөхөд Компаниас олгох боломжтой мөнгө байхгүй.

145. ***In Re London болон Caledonian Marine Insurance***-ийн иш татсан хэргийн зааврыг ашиглан, харж, сонссон бүх зүйлээсээ дүгнэн өөрөө ийнхүү асуулаа. ХТБ нар Компанийг татан буулгахын тулд чадах бүхнээ хийсэн үү? Тэд шаардлагатай бүх шалгах лавлах хэрэг бүртгэлийн ажиллагааг хийж, боломжийнхоо хэр хэмжээнд холбогдох мэдээллийг хайж байсан уу? Тэд чадах чинээгээрээ хөрөнгөө захиран зарцуулсан уу? Энэ хэргийн бүх нөхцөл байдалд, энэ үе шатанд хариулт нь тийм байна. Дээрх хэрэг кейс авч хэлэлцсэнээр, энэ хэсгийн үгсийн бодит, мэдрэмжтэй утга агуулгыг ашиглах зэрэг нь хэрэв үлдэгдэл ганц хөрөнгө байвал Компанийн үй ажиллагааг татан буулгасан гэж үзэхгүй гэсэн үг биш юм. Энэ нь ялангуяа ийм арга хэмжээ авахтай холбоотой томоохон эрсдэл, зардал гарах магадлалтай тохиолдолд ийм арга хэмжээ авах санхүүжилт байхгүй бөгөөд болзошгүй үр дүн нь зээлдүүлэгчид ямар ч ашиггүй байна. ХТБ нар үүнийг баталж чадах хэмжээний байр суурьтай хүнээс өргөн хүрээтэй, нарийвчилсан мэдээлэл авахыг эрэлхийлсэн. Тэд гуравдагч талын эх сурвалжаас мэдээлэл авсан. Тэд хүлээн авсан бүх мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн. Аливаа асуудлыг дангаар нь тодорхойлохгүй ч, ноён Лигийн хийсэн зөрчилтэй мэдэгдэл, үйлдлийн үр дагавар нь түүний өгсөн баримт бичиг эсвэл өөр аргаар олж авсан баримт бичигтэй зөрчилдөж байгаа тохиолдолд мэдүүлэгт

ач холбогдол өгч, зохих ёсоор шалгана гэсэн үг юм. Зээлдүүлэгчид холбогдох бичиг баримтыг бүрдүүлж, мэдээлэл авч, баримт бичгийг ХТБ-д хүргүүлсэн. Шүүхэд үнэлгээ дүгнэлт хийхэнд шаардлагатай хангалттай мэдээлэл өгөгдсөн.

146. Эдгээр бүх шалтгааны улмаас Шүүхэд байгаа бүх нотлох баримтыг авч үзэн, ХТБ-ын хүргүүлсэн мэдүүлгүүдийг хүлээн зөвшөөрч, Компанийн үйл ажиллагаа бүрэн тараагдаж, татан буугдсан явдалд сэтгэл хангалуун байна.

147. Мөн ХТБ гишүүд Эцсийн Тайлангаа нийтэлж, ирүүлсэн, татан буулгах шүүх хуралдааны товыг зээлдэгчид өгсөн, мөн сонсгол хурлын товыг CWR-ын 22 дугаар Тушаалын дагуу зарласанд сэтгэл хангалуун байна. Эцэст нь татан буулгах тухай захирамж гаргуулах, түүнийг дагаж гарах үр дагаварын захирамжийн хүсэлтийн хамт зохих ёсоор хангаж, гаргах боломжтой болсон явдалд би сэтгэл хангалуун байна.

Эрхэм хүндэт шүүгч Шерил Ричардс К.С
Дээд шүүхийн шүүгч

ИСПЕРА ХХК
TRANSLATION BUREAU